



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.02.05 №05 (10682)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР САНАЛ СОЛИЛЦОВ



Монгол Улсын Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Х.Батбилэг 1 дүгээр сарын 30-ны өдөр ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дэргэдэх Цэрэг, агаарын цэргийн атташе, хурандаа Павел Григорьевич Анисовыг хүлээн авч уулзлаа. Уулзалтын эхэнд бригадын генерал Х.Батбилэг "Манай сайхан оронд шинэ албанд томилогдсонд баяр хүргэе. Монгол Улс, ОХУ нь урт хугацааны сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааны түүхэн уламжлалтай. Энэхүү харилцааны чухал хэсэг нь цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагаа бөгөөд Монгол Улсын Зэвсэгт хүчнийг зэвсэглэл, техникээр хангах, шинэчлэн сайжруулах, цэргийн

боловсон хүчин бэлтгэхэд ОХУ-аас тусламж үзүүлж байдагт Монгол Улсын төр, засаг болон БХЯ, ЗХЖШ-ын удирдлага гүн талархалтай байдаг" гэв. Мөн тэрээр энэ онд тохиож буй Аугаа их Эх орны дайны ялалтын 75, Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн олон ажил, арга хэмжээ байгааг ч нэмж онцолсон юм. Харин хурандаа Павел Григорьевич Анисов "ОХУ-ын цэргийн атташе 1967 оноос Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дэргэд ажиллаж ирсэн түүхтэй. Энэхүү түүхэн уламжлалыг үргэлжлүүлэн ажиллах болсондоо баяртай байна" гээд цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Үүний дараа Батлан

хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Х.Батбилэг БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе, ахлах хурандаа Бао Юи Хайг хүлээн авч уулзсан юм. Тус уулзалтаар хоёр орны хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа гүнзгийрэн хөгжиж байгааг тэмдэглээд, өнгөрсөн онд Монгол Улс, Хятад улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд олон чухал арга хэмжээг хамтран зохион байгуулснаа дурдав. Мөн хоёр орны хамтарсан сургуулийг үргэлжлүүлэх, "Аравт" морин цэргийн олон улсын уралдаанд Хятадын талаас морьтон дайчдаа оролцуулах зэрэг асуудлаар санал солилцсон юм.

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бахархам түүх, дайчин алдрыг мөнхлөн баяжуулах үйл хэрэгт жинтэй хувь нэмэр оруулсан чөлөөнд байгаа болон бэлтгэл генерал, офицер, ахлагч, тус салбарын өнөөгийн хөгжилд бахдам амжилтыг гаргаж яваа нийт цэргийн алба хаагчид, ажилтнууд, сонины үе үеийн редакцын хамт олон, сонины нийт захиалагч, уншигч та бүхэндээ "Соёмбо" сонины анхны дугаар хэвлэгдсэний яруу алдарт 96 жилийн ойн мэндийг өргөн дэвшүүлье.

Өнгөрсөн түүхэн хугацаанд тус сонины редакцын хамт олон иргэний нийгэмд батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг ил тод, нээлттэй сурталчлах, уншигчдад эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, ололт амжилтаа үнэлэн цэгнэж, дараагийн зорилго, зорилтоо тодорхойлох эрхэм үүргээ бахархал дүүрэн гүйцэтгэсээр байна.

Сонины анхны дугаар "Ардын цэрэг" нэртэйгээр 1924 оны 2 дугаар сарын 5-ны өдөр хэвлэгдсэн түүхтэй бөгөөд 1929-1930 онд "Улаан цэргийн соёлын зам", 1930-1944 онд "Улаан Одон", 1944-1990 онд "Улаан од", 1990-1997 онд "Тусгаар тогтнол" нэртэйгээр хэвлэгдэн уншигчдад хүрч байлаа. Харин 1997 оны 4 дүгээр сараас "Соёмбо" нэрээр уншигчдын танил болж, тэдний оюуны эрэлт хэрэгцээг тогтмол хангаж байна.

Тус сонины редакц 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайны жилүүдэд дайны голомтод үүрэг гүйцэтгэж "Эх орны төлөө" нэртэй фронтын сонины нийт 130 гаруй дугаарыг хэвлэн офицер, дайчдыг ялалтад зоригжуулах, цаг үеийн мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх түүхэн үүргийг амжилттай гүйцэтгэснийг бид мартаж учиргүй. Тэрчлэн тус сонин манай улсын хэвлэл, мэдээллийн ууган байгууллагын хувьд өнгөрсөн зуунд хамгийн олон уншигчидтай, эрэлт ихтэй хэвлэл байж, салбарын 2010, 2013, 2014 оны шилдэг сониноор шалгарсан түүхэн амжилтаар манай хамт олон цаг ямагт бахархаж байдаг юм.

Сонины хамт олны нөр их хөдөлмөр, идэвх зүтгэл, бүтээлч үйл ажиллагааг төр, засгаас өндөрөөр үнэлэн сонины 25 жилийн ойг тохиолдуулан 1949 онд Байлдааны гавьяаны улаан тугийн одон, 50 жилийн ойн баяраар 1974 онд Сүхбаатарын одонг тус тус хүртээсэн бөгөөд сонины үе үеийн ажилтнуудынхаа хөдөлмөрч, дайчин уламжлалыг өнөөгийн залуус бид түүчээлэн яваадаа сэтгэл нэн хангалуун байна.

Бид өнгөрөгч 2019 онд сониныхоо түүхт 95 жилийн ойг үе үеийн ажилтнуудынхаа хөдөлмөр, бүтээлийг үнэлж алдаршуулж, сонины редакц бүрийн онцлогийг тусгасан гэрэл зургийн үзэсгэлэн гаргах, баримтат кино болон сонины дууг бүтээх, шилдэг бүтээлийн дээжсийг хэвлүүлэх бүтээлч ажлуудын дор өргөн дэлгэр тэмдэглэсэн юм. Мөн Батлан хамгаалах яамны харьяа нийт байгууллагууд, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудыг хамруулсан мэдээ, сурвалжилга, нийтлэлийг бэлтгэж, уншигчдынхаа эрэлт хэрэгцээнд тулгуурласан нийтлэлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж чадлаа.

Өнөөдөр "Соёмбо" сонин жилд 52 дугаар, "Цэргийн шинэчлэл" сэтгүүлийн дөрвөн дугаарыг бэлтгэн уншигчдын хүртээл болгож байгаа бөгөөд бид цэргийн сонины түүх, уламжлалыг түүчээлэн хөгжүүлэх, уншигч-захиалагчдын хүрээгээ тэлэх эрхэм зорилгыг тавин ажиллаж байна.

Тус сонин, сэтгүүлийн хэвлэлтийн тоог олшруулах, нийтлэлийн чанар, хүртээмжийг сайжруулах, захиалагчдын тоо, уншигчдын цар хүрээг нэмэгдүүлэх, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэд, олон нийт, гэр бүл, найз нөхдөдөө сурталчлах үйл хэрэгт эрхэм таны бүтээлч оролцоо, бодит хувь нэмэр их бөгөөд манай сонины редакцын хамт олны зүгээс таны санал, санаачилга бүхнийг дэмжиж хамтран ажиллах болно.

Сайн үйлс бүхэн дэлгэрч, санасан бүхэн тань бүтэх болтугай!


"СОЁМБО" СОНИНЫ ЭРХЛЭГЧ, ХУРАНДАА Б.ОТГОНБАЯР

ЦЭРГИЙН БҮРТГЭЛ 88 ХУВЬТАЙ БАЙНА



Цэргийн албаны тухай хууль болон Цэргийн бүртгэл явуулах журмыг үндэслэн Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1248 дугаар захирамжийн дагуу цэргийн шинэчилсэн бүртгэл нийслэлийн хэмжээнд 1 дүгээр сарын 20-ны өдрөөс нутгийн захиргааны анхан шатны нэгж болох хорооны Засаг даргын ажлын байранд зохион байгуулагдаж байна. Шинэчилсэн бүртгэл 2 дугаар сарын 7-ны өдөр хүртэл үргэлжлэх бөгөөд 2 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар бүртгэлийн явц 88 хувьтай байгаа талаарх мэдээллийг Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас өглөө. Бүртгэлийн явцтай ЗХЖШ-ын холбогдох удирдлагууд танилцаж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн бол Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас цэргийн бүртгэл хариуцсан алба хаагчдад халдвараас сэргийлэх зөвлөмжийг хүргүүлж, амны хаалт хэрэглэн гарыг байнга ариутгаж байхыг даалгасан байна. Цэргийн бүртгэл нь нэрийн ба тоон гэсэн төрлөөр явагдаж байгаа бөгөөд нэрийн бүртгэлийг дүүргүүдийн хороо, тоон бүртгэлийг дүүргүүдийн ЗДТГ-ын Цэргийн штаб хөтөлдөг ажээ.

ЯЛАЛТЫН ОЙГ ХАМТРАН ТЭМДЭГЛЭХ ТУХАЙ ЯРИЛЦЖЭЭ



Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Д.Даваа хүсэлт гарган ОХУ-ын Батлан хамгаалахын орлогч сайд А.В.Фоминг хүлээн авч уулзжээ. Уулзалтаар талууд хоёр орны Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа идэвхтэй хөгжиж байгааг дурдаад энэ жил тохиож буй Аугаа их Эх орны дайны ялалтын 75 жилийн ойн баярын арга хэмжээг хамтран тэмдэглэн өнгөрүүлэх асуудлаар санал солилцсон байна. Тус уулзалтад Монгол Улсын талаас Цэргийн атташе, бригадын генерал Г.Энхбаатар, Оросын талаас ОХУ-ын Батлан хамгаалахын орлогч сайдын референт, хурандаа С.Н.Саратов, ОХУ-ын БХЯ-ны Олон улсын цэргийн хамтын ажиллагааны ерөнхий газрын тавдугаар газрын дарга, хурандаа М.В.Пенкин нарын албаныхан оролцжээ.

Ярилцах цаг

О.Энхбаяр: БАЙЛДААНЫ ЖИЖҮҮРЛЭЛТИЙН НЭМЭГДЛИЙГ ШИЙДВЭРЛЭНЭ

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, бригадын генерал О.ЭНХБАЯРТАЙ цаг үеийн асуудлаар ярилцлаа.

Төрлийн цэргийн командлалууд бие даан үйл ажиллагаа явуулж эхлээд гурван жил өнгөрлөө. Энэ хугацаа бие даасан байдалдаа үнэлэлт дүгнэлт өгч, үр дүнгээ харсан цаг үе гэж ойлгож байна...

-Улсын Их Хурлаар шинэчлэн батлагдсан Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичиг болон Батлан хамгаалахын багц хуулийн хүрээнд 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал бие даан үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Бие даан үйл ажиллагаа явуулснаас хойших хугацааг гурван өгүүлбэрээр тодорхойлмоор байна. Нэгдүгээрт, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал бие даасан байдлаараа төлөвшиж байна. Мэдээж төлөвшөөд дууссан гэж хэлэхгүй ч үндсэн голдиролдоо орчихлоо, бид. Хоёрдугаарт, харьяа анги,

салбаруудаа удирдах, командлалаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд татан оролцуулах, гүйцэтгүүлэх зэрэг захиргаа, удирдлагын түвшинд юуг анхаарах, юу нь болж байна вэ гэдгийг нэлээд ойлгоод авчихлаа. Гуравдугаарт, цаашид яах ёстой вэ гэдгээ цогц байдлаар дүгнэж байна.

Агаарын цэргийн хууль, эрх зүйн шинэчлэлийн хувьд...

-Эрх зүйн шинэчлэлийн ажил одоо ч үргэлжилж байна. Нэг дүрэм, журмын цаана судалгаа шинжилгээ, цаг хугацаа зарцуулагддаг учраас ингэхээс өөр аргагүй юм. Ялангуяа, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болдог баримт бичгүүдээ эхний ээлжид шинэчилж гаргах шаардлага байна. Зэвсэглэл, техникийн талаар гэхэд л Зөвлөлтийн үеэс дагаж мөрдөж байсан дүрэм, журам голдуу байгаа. Үүнийг монгол хэлнээ хөрвүүлж, өөрийн онцлог шинжид

тохируулах, орчин үеийн байлдааны ажиллагаатай уялдуулах зэрэг хийж хэрэгжүүлэх олон ажил бидний өмнө хүлээж байна. Хийж хэрэгжүүлсэн, боловсруулж батлуулсан нь ч их байна. Өнгөрсөн жил гэхэд Улсын Их Хурлаар Улсын нисэхийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан багц дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулан Батлан хамгаалахын сайдаар батлуулан байлдааны дүрэм, журам, заавруудыг ч шинэчиллээ. Цаашид ч хууль, эрх зүйн баримт бичгүүдэд нийцүүлэн батлуулах шаардлагатай хэд хэдэн дүрэм, журам, заавар бий.

Агаарын цэргийн командлалын гадаад харилцаанд нэлээд ахиц гарч байна. Энэ тухай тодруулахгүй юу?

-Манай командлалын хувьд 2019 он гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн амжилт дүүрэн жил байлаа. Нэгдүгээрт, Энэтхэг, Номхон далай дахь АНУ-ын Агаарын хүчний командлалтай анхдугаар зөвлөлдөх

уулзалтыг хийж, цаашдын харилцаа, хамтын ажиллагаагаа тодорхойллоо. Энэхүү уулзалт нь хоёр улсын цэргийн хамтын ажиллагаанд томоохон байр суурийг эзлэх учиртай. Хоёрдугаарт, Монгол Улс, ОХУ-ын цэргийн хамтын ажиллагааны хүрээнд хэд хэдэн чиглэлээр буцалтгүй тусламжийг хүлээн авах ажил үргэлжилж байна. Үүний зөвхөн нэг нь сургууль-байлдааны зориулалттай хоёр сөнөөгч онгоц байв. Эдгээр онгоц нь агаарын цэргийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх чадварыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. Өдгөө бидний өмнө сөнөөгч онгоцоороо нисэх, цаашлаад өөрсдөө засвар, үйлчилгээгээ хийж сурах ажил хүлээгдэж байна. Инженер, техникийн бүрэлдэхүүн, нисгэгчдээ энэ чиглэлийн сургалтад хамруулах хүсэлтэй байгаагаа ОХУ-ын талд илэрхийлсэн. Удахгүй нааштай шийдвэр ирнэ гэдэгт итгэж байна.

(Үргэлжлэл нь II нүүрт)

О.Энхбаяр: БАЙЛДААНЫ ЖИЖҮҮРЛЭЛТИЙН НЭМЭГДЛИЙГ ШИЙДВЭРЛЭНЭ

(Түрүүч нь I нүүрт)

Нөгөө талаас инженер, техникийн өндөр мэдлэгтэй залуус маань нэгдээд инновац шингэсэн бүтээл гаргах болсон нь тун сайшаалтай. Тухайлбал, агаарын бүсийн мэдээллийг хүлээж авах, боловсруулах ажиллагааг автоматжуулах чиглэлээр орчин үеийн програм хангамж бүтээж байх жишээтэй. Туршилтаар баталгаажсан бүтээл. Хэдийгээр хөрөнгө шаардаж байгаа ч явцын дунд үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шаардлага бий гэж харж байгаа.

Цаашид хамтын ажиллагаа тогтоох, өргөжүүлэх ямар орнууд байгаа вэ?

-БХЯ, ЗХЖШ-ын нэг цонхны бодлогоор явах ёстой. Түүнээс биш энэ улсын тэр байгууллагатай хамтарч ажиллана гээд төлөвлөгөө, хөтөлбөр гаргаад байх боломжгүй. БХЯ, ЗХЖШ-ын удирдлагууд гадаад хамтын ажиллагааны уулзалтуудаар "Агаарын цэргийг хөгжүүлэх" тухай байнга шахам ярьж, санал солилцож байгаа нь бидний хувьд том амжилт юм.

Харьяа анги, салбарынхаа алба хаагчдын нийгмийн хамгааллыг дээшлүүлэх чиглэлийн



тухайд ...

-2019 онд БХЯ, ЗХЖШ-ын удирдлагын дэмжлэгтэйгээр хоёр тусгай салбарт тус бүр найман айлын албан тушаалын байр барилаа. 2018 оноос эхэлсэн ажил л даа. Үүн дээр нэмэгдээд өөр нэг тусгай салбарын найман айлын албан тушаалын орон сууц бэлэн болж байна. Нэг салбарын найман өрхийн цаана тэдний гэр бүл, үр хүүхдүүд ая тухтай орчинд амьдрах орчин бүрдэж байгаа нь хамгийн чухал. Эсгий

гэр түрээслээд амьдарч байсан үетэй харьцуулахад том амжилт шүү. Энэ бол тэнд алба хааж байгаа офицер, ахлагч нарын тогтвор суурьшилтай, сэтгэл санаа тайван ажиллахад том хөшүүрэг болох нь ойлгомжтой. Үүнээс гадна байлдааны жижүүрлэлтийн бүрэлдэхүүний нэмэгдлийн асуудлыг ЗХЖШ-ын даргын зөвлөл, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар оруулан шийдүүлэхээр ажиллаж байна. Үргэлжлүүлээд Засгийн

газрын хуралдаанаар оруулна. Хариуцлагатай үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын маань нэмэгдлийг шийдвэрлэнэ гэдэгт итгэж байгаа. Хоёрдугаарт, алслагдсан анги, салбарт алба хааж байгаа бүрэлдэхүүнд хүнсний хангалт өгдөг. Хүнсний эл хангалт энэ жилээс тодорхой хэмжээгээр нэмэгдсэнийг хэлэхэд таатай байна. Гуравдугаарт, хуулийн дагуу алслагдмал анги, салбарт алба хааж байгаа офицер, ахлагч нарын сургуулийн насны нэг хүүхдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр улиралд нэг удаа мөнгөн тусламжийг үзүүлэх ёстой. Үүнийг тасралтгүй олгож байна. Энэ нь алба хаагчдад маань маш том түлхэц шүү. Мөн алслагдмал анги, салбарт таван жил ажилласны урамшуулал гэж бас бий. Энэ нь мэтчилэн эх орныхоо дөрвөн зүг, найман зовхист эх орноо батлан хамгаалж буй бүрэлдэхүүнээ дэмжээд ирэхээр тэнд очиж үүрэг гүйцэтгэх сонирхолтой цэргийнхний тоо нэмэгдэж байна. Ер нь байр, орон сууц нь байвал залуус орон нутагт ажиллах хүсэл тэмүүлэлтэй болсон нь ажиглагддаг.

Цаашид албан тушаалын байр нэмэгдэх үү?
-Бидэнд бодож төлөвлөсөн зүйл бий.

2020 онд Агаарын цэргийн командлалаас ямар зорилт дэвшүүлэн ажиллаж байна вэ?

-Хэд, хэдэн зорилт тавилаа. Нэгдүгээрт, улс орны эдийн засаг хүнд байгаатай холбогдуулан томоохон хөрөнгө шаардахгүйгээр цэргийн сургалт бэлтгэлээ тасралтгүй явуулна. Өнгөрсөн жилүүдэд тактикийн нэгдсэн сургуулиудыг явуулаад сурчихлаа. Шинэлэг ажиллагаануудыг орчин үеийн шаардлагад нийцсэн байдлаар туршсан нь том ололт байв. Хоёрдугаарт, штабын бэлтгэлжилт, тактикийн сургууль, засвар, үйлчилгээ явуулахтай холбоотой сургалтуудыг тасралтгүй явуулна. Гуравдугаарт, бүтэц, орон тооны өөрчлөлтэй холбогдуулан хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, алба хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах болон бусад үүрэг гүйцэтгэлтэй холбоотой төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулах гээд төлөвлөсөн олон ажил бидний өмнө бий. Энэхүү зорилтуудаа бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн төлөө манай командлалынхан дарга, цэрэггүй цөмөөрөө зүтгэнэ дээ.

Дэслэгч Д.БОЛОРМАА

Хилийн чанадаас

ШИЛДГҮҮДЭЭ ШАЛГАРУУЛЛАА

БНӨСҮ-д явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний IX ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүн шинэ оны эхний сард хийж бүтээсэн ажлаа тайлагнаж, ололт амжилтаа хэлэлцэн дүгнэв. Нэгдүгээр сард "Тэргүүний штабын офицер"-оор ахмад Б.Цээноров /350/, "Тэргүүний салбарын офицер"-оор ахмад М.Нарантулга /150/, "Тэргүүний ахлагч"-аар сургагч ахлагч А.Бат-Очир /330/, ахлагч ахлагч Р.Батбаяр /ҮБХИС/, ахлагч Б.Түвшинтөр /015/ нар шалгарсан юм. Мөн "Тэргүүний шинийг санаачлагч, бүтээлч цэргийн алба хаагч"-аар дэд ахлагч Н.Бат-Эрдэнэ /ЦЕГ/, "Тэргүүний эмэгтэй цэргийн алба хаагч"-аар дэд ахлагч Э.Эрдэнэцэцэг /353/, "Тэргүүний салаа"-гаар дэслэгч Д.Өнөрбаатар /325/ захирагчтай салааны хамт олон шалгарлаа. Тэргүүний цэргийн алба хаагчдынхаа шагналыг Цэргийн тангараг давтах ёслолын ажиллагааны үеэр гардуулж баяр хүргэсэн бөгөөд тэдний анги, салбар, ар гэрийнхэнд нь "Талархлын захидал" илгээв.

ҮНДЭСНИЙ СОЁЛ, УЛАМЖЛАЛАА СУРТАЛЧЛАВ

Гана улсын мотобуудлагын батальон олон улсын загварын шоу-го зохион байгууллаа. Тэд НҮБ-ын "UNMISS" ажиллагаанд мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэж байгаа орнуудын цэргийн алба хаагчдыг урьж оролцуулан



өөр өөрийн үндэсний түүхэн уламжлал, ёс заншил, соёл урлаг, хувцас хэрэглээг сурталчлах, харилцан танин мэдэх боломжийг олгосон юм. Тус шоу-нд зохион байгуулагч орноос гадна Монгол, Англи, Вьетнам улсын энхийг сахиулагчид оролцсон бөгөөд манайхан хуураа татаж, "Эр бор харцага"-аа шуранхайлсан ба цуур, товшуураа хөглөж Алтай, хангайгаа магтан хайлав. Басхүү "Хөдөөгийн залуус"-аа хөглөн бүжиж, хүчит бөхчүүд хуурин шуугилснаар хүрэлцэн ирсэн олныг эрхгүй суудлаас нь өндөлзүүлэв. Өөрсдөө бид үндэсний гэсэн бүхнээрээ бахдав. Ийнхүү НҮБ-ын удирдлагуудын төлөөлөл, энгийн ажилчин албан хаагчид, хаяа айлсан хамтран үүрэг гүйцэтгэж буй бусад орны энхийг сахиулагчдад үндэсний өв уламжлал, зан заншил, урлаг соёл, хувцас хэрэгслээрээ гайхууллаа.

Ахмад Д.МЭНДБАЯР

Цаг үеийн зөвлөмж

ШИНЭ КОРОНАВИРУСЫЙН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

БНХАУ-ын Хубэй мужийн Ухань хотод 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр шинэ коронавирус (2019-nCoV)-ийн халдвар бүртгэгдсэн бөгөөд энэхүү халдвар өвчин тархаж эхэлснээс хойш 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 10.00 цагийн байдлаар дэлхийн 24 оронд 24483 батлагдсан тохиолдол бүртгэгдэж, үүнээс 491 хүн нас барж, 892 хүн бүрэн эдгэсэн ба Филиппин улсад нэг, БНХАУ-д бусад нас барсан хүмүүс бүртгэгджээ. Шинэ коронавирус нь дэлхийн хэмжээнд бүртгэгдэж байгаагүй бөгөөд энэ өвчний вирусийн халдвар нь хүнээс хүнд амьсгалын замаар халдварладаг, нууц үеийн хугацаандаа халдвар дамжуулдаг байж болзошгүй эрсдэл өндөр, нууц үеийн хугацаа 14 хоног үргэлжилдэг, халуурах, ханиах, амьсгал давчдах, цээжээр өвдөх, гүйлгэлт, суулгалт, хоол боловсруулах эрхтний хямралын шинж тэмдгээр илэрч, улмаар уушгины хатгаа, бөөний дутагдлаар даамжирдаг амьсгалын замын хурц халдварт өвчин юм. ДЭМБ-аас шинэ коронавирусийг бүх улс оронтой хамтран судалгаа, шинжилгээний ажлыг эрчимтэй эхлүүлэн энэхүү халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, түүний эмчилгээг гарган авахаар идэвхтэй ажиллаж байна.

Цахим орчинд эдийн засгийн болон улс төрийн сонирхолтой хандалт авах зорилгоор шинэ коронавирусийн халдварын талаар батлагдаагүй мэдээллүүд цацагдаж байгаа тул ЭМЯ (www.mohs.mn) ДЭМБ (www.who.int) ХӨСҮТ (www.ncsd.gov.mn болон facebook)-ийн албан ёсны мэдээллийг "Олон улсын эрүүл мэндийн дүрэм"-ийг баримтлан үнэн, зөв гэж үзэж байгаа юм. Монгол Улсын хэмжээнд одоогийн байдлаар энэхүү халдварт өвчний тохиолдол бүртгэгдээгүй, сэжигтэй 71 хүнийг ХӨСҮТ-д тусгаарласан бөгөөд тэдний шинжилгээний хариу бүгд сөрөг (шинэ коронавирусийн халдваргүй) гарсан байна. "Сэжигтэй тохиолдол" гэдэг нь халуурч, ханиалгаж, өөрөө болон ойр дотнын хүмүүсээс сүүлийн 14 хоногийн хугацаанд БНХАУ-д зорчсон өгүүлэмжтэй хүмүүс юм. Хэрэв "сэжигтэй тохиолдол" гэж үзэхээр бол зөвхөн ХӨСҮТ-д хандаж, шинжилгээнд зайлшгүй хамрагдах шаардлагатай онцгой анхаарах хэрэгтэй.

Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 19 дүгээр албан даалгавар, Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч даргын 2020 оны 2/107 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэн, Зэвсэгт хүчний Хяналт шалгалт, үнэлгээний газар, ЗХЖШ-ын Ар талын газрын Эрүүл мэндийн хангалтын хэлтсээс шинэ коронавирусийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулан, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын эмч, сувилагч, ажилчидтай хамтран ажиллаж, удирдлагыг цаг үеийн шуурхай мэдээллээр хангаж байна.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

- 1.Хувийн ариун цэвэр, гарын ариун цэврийг сахиж сайтар угаан ариутгаж хэвших нь халдвар дамжихаас сэргийлнэ;
- 2.Амны хаалтыг тогтмол, зөв хэрэглэж, ханиаж найтаахдаа алчуур салфетик ашиглах;
- 3.Шаардлагагүй тохиолдолд хүн олноор цугласан газар очихоос зайлсхийх;
- 4.Халдвар бүртгэгдсэн улс орноор зорчихоос татгалзаж, зайлшгүй шаардлагатай тохиолдолд халдвар хамгааллын дэглэмийг сахиж мөрдөх;
- 5.Илчлэг сайтай хоол, хүнс хэрэглэж, ажил, амралтын горимыг зохицуулах;
- 6.Чийгтэй цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтлэлийг спирт болон жавелионы 0.015% (10 л усанд 1 шахмал жавелион уусгасан)-ийн уусмалаар тогтмол хийх нь халдвар дамжих эрсдлийг багасгана.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр зөвхөн шинэ коронавирусийн халдвараас гадна бусад халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой бөгөөд энэхүү заавар, зөвлөмжийг алба хаагч бүр мөрдөн ажиллахыг онцгойлон анхааруулж байна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

Даланзадгад сумын иргэдэд 200 ширхэг амны хаалт, 380 ширхэг гарын авлага, 10 литр аарц, чацаргана, коронавирусуудыг урьдчилан сэргийлэх зөвлөмж зэргийг тус тус тараасан юм.

Ахмад Ё.БАТ-ЭРДЭНЭ

326 дугаар анги

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас "Монголын хүний нөөцийн удирдлага, шинэчлэлийн академи"-тай хамтран харьяа нэгтгэл, ангиудын хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан офицеруудад 11 хоногийн хугацаатай хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, албан хэрэг хөтлөлт зэрэг сэдвээр нийт 87 цагийн хичээл орж, онол, арга зүйн мэдлэгийг эзэмшүүлж, сертификат гардуулсан юм.

Дэд хурандаа Н.БАТЖАРГАЛ

337 дугаар анги

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бие бүрэлдэхүүний хуулийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хэд хэдэн арга хэмжээг зохион байгуулж байна. Үүний хүрээнд Налайх дүүргийн Цагдаагийн газрын цагдаагийн хошууч Б.Батбилгүүн, Ц.Зоригт нар "Зөрчлийн тухай хууль", "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", "Замын хөдөлгөөний аюулгүй байдал" зэрэг чиглэлээр бие бүрэлдэхүүнд яриа, таниулгаа хийсэн юм.

Ахмад А.БААСАНПҮРЭВ

Редакцын шууданд

АЦК

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл"-өөс харьяа анги, салбаруудад хууль тогтоомж сурталчлах, бие бүрэлдэхүүний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор "Хуулийг хэн сайн мэдэх вэ?" болзолт уралдааныг 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нэг сарын хугацаатай зохион байгуулна. Уг уралдаан цэргийн алба хаагчдын заавал судлах эрх зүйн баримт бичгийн жагсаалтын дагуу 16 хууль, эрх зүйн актын хүрээнд явагдана. Энэхүү уралдаан зохиогдсоноор цэргийн алба хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг болон ёс суртахууны хандлагыг дээшлүүлэх, салбарын болон бусад хууль, эрх зүйн актын хэрэгжилтийг хангахад тэдний идэвх, оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд өндөр ач холбогдолтой юм.

Тэргүүн ахлагч О.БАТБАЯР

167 дугаар анги

*2020 оны Самбо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээн 1 дүгээр сарын 16-19-ний өдрүүдэд зохион байгуулагдлаа. 12 дахь жилдээ зохиогдсон тус тэмцээнд ангийн ахлагч Э.Мөнхямба 52 килограммын жинд амжилттай оролцож, дэд байрт шалгарав.

*ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга болон Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын даргын албан даалгавруудын хүрээнд тус ангийн офицерууд "Коронавирусуудыг урьдчилан сэргийлэх" сэдэвт сайн үйлсийн аяныг санаачлан зохион байгууллаа. Тус аяны хүрээнд Өмнөговь аймгийн

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс 2020-2021 онд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд штабын болон цэргийн ажиглагч, холбогч офицерууд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагчдын нэмэлт сонгон шалгаруулалтыг 2020 оны 3 дугаар сарын 2-6-ны өдрүүдэд зохион байгуулна.

Уг сонгон шалгаруулалтад хамрагдах хүсэлтэй цэргийн алба хаагчид 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн дотор ЗХЖШ-ын Энхийг дэмжих-цэргийн хамтын ажиллагааны хэлтэст дараах материалыг бүрдүүлэн ирүүлнэ үү.

Сонгон шалгаруулалтад хамрагдах цэргийн алба хаагч нь дараах үндсэн шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- 1.Монгол Улс, Зэвсэгт хүчний нэр хүндийг өндөрт өргөн үүрэг гүйцэтгэх ёс суртахууны төлөвшилттэй, цэргийн мэргэжлийн ур чадвартай, ажлын үр дүн, сурлага, сахилгаар тэргүүлэгч, эрсдэлийг ойлгож түүнийг даван туулах чадвар, сэтгэл зүйн бэлтгэлжилттэй, Зэвсэгт хүчний анги, салбарт мэргэжлийн сургууль төгссөнөөс хойш таваас доошгүй жил ажиллаж байгаа ахмадаас дэд хурандаа цолтой офицер;
- 2.Эрүүл мэнд, цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандартыг бүрэн хангадаг байх;
- 3.Англи хэлний гүнзгий шатны мэдлэгтэй байх (Шалгалтыг яриа, бичиг, сонсгол, унших зэрэг дөрвөн чадвараар авна);
- 4.Механик хурдны хайрцагтай 4x4 загвар бүхий дунд оврын жийп автомашиныг жолоодож дадлагажсан, авто техник өдөр тутмын үйлчилгээ бие даан гүйцэтгэх дадлагатай;
- 5.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг, гэмт хэрэгт холбогдож байгаагүй;
- 6.Зан харьцаа, ёс суртахууны доголдол, элдэв гаж зуршилгүй байх;
- 7.Энхийг дэмжих ажиллагаанд цэргийн багт үүрэг гүйцэтгэж байсан туршлагатай байх.

Сонгон шалгаруулалтад хамрагдах цэргийн алба хаагч нь дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- 1.Харьяа анги, салбар, командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;
- 2.Ажил байдлын тодорхойлолт;
- 3.Анги, салбарын даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл (Сонгон шалгаруулалтад хамруулах);
- 4.Жолооны үнэмлэхийн хуулбар;
- 5.Энхийг дэмжих ажиллагааны чиглэлээр суралцсан сургууль, дамжааны сертификатын хуулбар;
- 6.Сүүлийн гурван сарын дотор авахуулсан 3x4 хэмжээтэй цээж зураг хоёр хувь.

Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг ЭДЦХАХ-ийн ЭДА-ны мэргэжилтэн, хошууч Э.Амартүвшин болон "psod@mil.gov.mn" мэйл хаягаар тодруулж болно.

ЗХЖШ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ-ЦЭРГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

ИНЖЕНЕРИЙН ЦЭРЭГ БҮТЭЭЛЧ АГААД ИЛҮҮ ...

Сүүлийн жилүүдэд улс орны хөгжилд өндөр ач холбогдолтой бүтээн байгуулалтын ажлууд ихээр хийгдэж байна. Тухайлбал, Дорноговь аймгийн Алтанширээ сум дахь зам, "Сайншанд-Тавантолгой" чиглэлийн төмөр зам гээд дурдаад байвал олон. Холыг ойртуулж, хоёрыг учруулах ашдын өрөөл бүхий, түүхийн хуудсанд тодоор бичигдэн үлдэх эдгээр бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний төлөөлөл тэр дундаа инженерийн цэргүүд голлох үүрэгтэй оролцож байгаа нь бахархуштай. Эгэл даруу, нам гүмхэн, хүлээсэн үүргээ мадаггүй биелүүлдэг, бүтээн байгуулалтын эзэд болсон инженерийн цэргүүдийг сурвалжлахаар сонины гэрэл зурагчны хамтаар Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийг зорьсон юм. Налайх чиглэлд шинээр тавьсан засмал зам зорьсон газар саадгүй хүргэхтэй зэрэгцээд үүн шиг замыг тус ангийнхан хөдөө орон нутагт тавьсан гэж бодохоор бахархам байсан бөгөөд үйлс бүтээлийн эздээс юу асуухаа ноороглон явлаа.

Энэ ангид ирэх бүртээ шинээр юу нэмэгдсэн, юуг шинэчлэн, сайжруулсан байгаа бол гэж сонинчирхан хараа хүрэх газраа ажаад амждаг. Учир нь инженерийн цэргүүд бүтээлч агаад цаанаа л нэг бусдаас илүү мэт. Үүнийг батлах мэт ангийн хаалгаар ороход л хэд хэдэн цэрэг өөрсдийн урласан шинэ тавилгыг дамжлан штабыг зорьж буйтай таарсан. Тэд урласаар л угтаж буй нь энэ.

2019 он тус ангийн хувьд харвасан сум шиг хурдан өнгөрсөн. Учир нь төлөвлөгөөт бүхий л ажил, арга хэмжээ, сургалт дадлагуудаа гүйцэтгэхийн зэрэгцээ дурдахгүй өнгөрч боломгүй улс орны бүтээн байгуулалтын ажилд оролцсон явдал юм. Энэ талаар ангийн захирагч, хурандаа С.Содов "Бидний оролцож байгаа бүтээн байгуулалтын ажлууд бол Монгол Улсын төр, засгаас даалгаж байгаа стратегийн том үүргүүдийн нэг учир инженерийн цэргүүд бид голлох үүрэгтэй оролцсон. Инженер, техникийн

Хүнд машин механизм, операторын ангид ахлагч нараа өвлийн улиралд дадлагуулах, цэргийн гэрээт алба хаагчдаа сургаж чадавхын үнэмлэх олгуулдаг бөгөөд жилд 30 гаруй цэргийн алба хаагчийг хамруулдаг аж. Энэ жил анх удаа 25 хугацаат цэргийн алба хаагчийг дээрх хүнд машин механизм, операторын ангид мэргэжлийн үнэмлэх олгох сургалтад хамруулжээ. Дээрх хугацаат цэргийн алба хаагчдыг сонгохдоо цаашид Зэвсэгт хүчинд, тэр дундаа инженерийн цэрэгт цэргийн гэрээт алба хаагч болон ахлагчийн албанд шилжих сонирхлыг нь харгалзан үздэг аж. Үгүй дээ гэхэд, эдгээр цэргийн алба хаагчдыг нэг насны хоолтой нь залуулж байгаагаараа онцлог юм. Мөн энд нэг зүйлийг тодруулж хэлэхэд чадавхын гэрчилгээ болон мэргэжлийн үнэмлэх хоёрын хооронд асар их ялгаа бий бөгөөд эдгээр цэргийн алба хаагчид энэ оны 3 дугаар сард эхлэх бүтээн байгуулалтын ажилд шууд оролцоод явах мэргэжлийн хүний нөөц болж байгаа юм.

Зэвсэгт хүчний инженерийн цэрэгт хүлээлгэх итгэл найдвар асар их болсныг тэрээр мөн хэлж байсан. 2018 онд Дорноговь аймгийн Алтанширээ сум дахь замын ажилд оролцож эхлэх үед нийгэм, хувийн хэвшлийнхэн Зэвсэгт хүчин чадах уу, замын ажил хийхэд эдгээр цэргийн алба хаагчид бэлтгэгдсэн үү гэх мэт асуулыг тавьж байсан бол 2019 оны сүүлч гэхэд энэ хандлага нь бүрэн өөрчлөгдсөн аж. Учир нь бид энд бэлтгэлгүй, шууд ханцуй шамлаад орж байгаа асуудал биш байсан. Олон жилийн өмнөөс ул суурьтай бэлтгэгдэж, дадлагдаж ирсэн. Тухайлбал, Япон улсын Өөрийгөө хамгаалах хүчинтэй хамтарсан "Зам" сургалтаар офицеруудаа инженерчлэлийн арга барилд сургах, механик жолооч нараа дадлагуулах ажлыг хангасан бол 2017 онд Аглаг бүтээлийн хийд дээр сургалт, бүтээн байгуулалт хэлбэрээр хүмүүсээ дахин дадлагуулсан. Тиймээс эдгээр ажил, арга хэмжээний хүрээнд хэмжилтийн болон талбайн инженерүүдээ мэргэшүүлэх, механик жолооч нараа техник дээр нь дадлагуулах цогц ажлыг хэрэгжүүлсэн. Үүнээс улбаалж мөн оны сүүлчээр Зэвсэгт хүчний 014 дүгээр анги "Авто зам барих тусгай зөвшөөрөл"-өө авсан. Тиймээс өнөөдөр цэргийн зохион байгуулалтын давуу тал, богино хугацаанд хүлээсэн ажлаа хэрхэн сайн гүйцэтгэж чаддагаа харуулаад байгаа юм. Энэ бүгдийн эцэст зарим зүйлийг маш томоор олзуурхаж харах хэрэгтэй юм. Тухайлбал, офицер, ахлагчийн бүрэлдэхүүнээс мэргэшсэн инженерүүд, механик жолооч, операторуудыг бэлтгэж чадсан. Энэ бол инженерийн цэргийн давуу тал болсон бөгөөд одоо тэд хаана ч өрсөлдөх чадвартай болж байгаа юм. Энэ бол нэг том боломж. Дараагийн дугаарт улс орны эдийн

засгаас шалтгаалан шинэчилж чадахгүй байсан газар шороо, замын техникүүдийн асуудлыг шийдэж чадсан явдал. Энэ бүгд Зэвсэгт хүчин, инженерийн цэрэгт үлдэх маш том баялаг.

Орхигдуулж боломгүй бас нэг асуудал бол ажилтан алба хаагчдын нийгмийн асуудал. Бүтээн байгуулалтын ажилд оролцоод эхлэхээр тус ангийн бие бүрэлдэхүүн доод тал нь зургаа, ес, заримдаа 11 сар ч томилолтоор үүрэг гүйцэтгэх тохиолдол гардаг. Энэ тохиолдолд залуу гэр бүлд үл ойлголцох асуудал үүсэх эрсдэл байгаагаас улбаалаад 2020 онд ар гэр лүү нь чиглэсэн сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, ангийн байрлалд ар гэрийнхнийг нь хүлээн авч уулзах, үүрэг гүйцэтгэж байгаа гэр бүлийнх нь гишүүдийн хийж байгаа ажил, үүргийг нь ойлгуулах зэрэг ажлыг төлөвлөдөг байгаа аж. Мөн тус бүтээн байгуулалтын ажлын хүрээнд цалингаас гадуурх нэмэгдэл олгогдож байгаа учир эдийн засгийн хувьд ололттой бөгөөд үүнийг дагаад оролцох бие бүрэлдэхүүний тоо нэмэгдээд байгаа юм.

Эдгээрээс гадна ангийн байрлалдаа тэднээс хийж хэрэгжүүлж буй ажил маш олон. Тухайлбал, "Гэрэлтүүлэг" төсөл хэрэгжүүлж ангийн байрлал бүхэлдээ шөнийн цагт ч өдөр мэт гэрэлтэй байх болжээ. Мөн харуулын үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагчдын ажиллах тухтай нөхцөл, сургалтыг зохион байгуулах боломжийг дээшлүүлэх зорилгоор "Харуулын танхим" төслийг хэрэгжүүлж Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд, Цэргийн албаны зохион байгуулах зааварт заасны дагуу амрах байр, ангийн байрлалын макетыг дотоод нөөц бололцоогоор төхөөрөмжлөн засварлаж, тохижуулсан аж. Мэдээж тус ангийн цэргийн гэрээт алба хаагчдын байрыг дурдалгүй өнгөрч боломгүй. Зэвсэгт хүчний жишиг цэргийн гэрээт алба хаагчдын байр болох нь нүднээ илт. Муухан айл



Дэд хурандаа Г.ЭРДЭНЭБААТАР

цаашаа, тохь тухтай агаад "... одтой" зочид буудлын дайны юм. Ангийн байрлалд хяналтын камеруудыг бүрэн байрлуулсан байх бөгөөд дээрх бүгдийн талаар ангийн штабын дарга, дэд хурандаа Г.Эрдэнэбаатар бидэнд мэдээлэл өгөхийн зэрэгцээ ангиа камержуулалтын тусламжтайгаар бүрэн хяналтдаа байлгаж харагдсан.

ТЭД НЭГ АНГИ

Зэвсэгт хүчин хэмээх их айлд алба хаадаг эхнэр нөхөр, аав хүү, ах дүү гээд төрөл төрөгсөд бишгүйдээ л олон. Тэдний төлөөлөл болсон нэг ангид ажилладаг ээж хүү хоёртой уншигч таныг уулзуулахыг зорилгоо.

Ээж Н.Бямбаа нь Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн талхан цехийн эрхлэгч. Тэрээр Зэвсэгт хүчинд 27 дахь жилдээ ажиллаж байгаа бөгөөд тус ангид 18 дахь өвөлтэйгөө золгож байгаа нэгэн. Түүний үндсэн үүрэг бол цэрэг дайчдаа амтат талхаар

байсан бөгөөд өөрийн хүсэл мөрөөдөлдөө үнэнч байж цэргийн зарлан дуудах хуудас ирэхэд нь ээжээсээ тас нуун ганцаараа цэрэг татлагын байр луу очсон гэдэг. Учир нь ээж Ж.Бямбаа нь "Цэргийн алба хүнд, ганц хүүгээ цэргийн алба хаалгахгүй шүү" гэж хэд хэдэн удаа хэлсэнтэй нь холбоотой аж. "Хаана алба хаамаар байна вэ" хэмээн цэрэг татлагын комиссын дарга асуухад нь "Би хил дээр алба хаамаар байна" гэж саналаа өгсөн хэдий ч хувь тохиол уу, аз завшаан уу, ямартаа



Ээж, дүүгийн хамт 2014 он

тасалдуулахгүй байхад чиглэгдэх бөгөөд өдөр бүр 75 килограмм гурилаар 125 ширхэг талх хийдэг. Урд нь гурилын чанараас шалтгаалан хар голдуу талх хийдэг байсан бол одоо чанар сайтай гурилаар амтлаг талхыг төрөл бүрээр нь хийж, өөрийн хүүхдүүдээс өөрцгүй ангийн бие бүрэлдэхүүнийг хооллож байгаадаа ихээхэн олзуурхдаг талаараа дурдана билээ. Мөн цэргийн алба амар алба биш, тэгээд ч гэрээсээ хол эцэг, эхээсээ холдоод удаагүй цэргүүд, олон хоног, сараар хээр хөдөө, албан тасалгаандаа үүрэг гүйцэтгэдэг офицер, ахлагч нарт гэрээ санах, үгүйлэх мэдрэмж төрүүлэхгүйгээр албаа амжилттай хаахад нь багахан ч гэсэн нэмэр болох гэж цэргийн гал тогооны хамт олонтойгоо хамаг хүчээ дайчлан амт чанартай хоол, цай, талх, нарийн боовоор үйлчлэхийг эрхэм зорилгоо болгодог доо хэмээн даруухан хуучлах түүний энэ байдал нь ажилдаа эзэн хүний ёсоор хандаж байгаа чин сэтгэл гэлтэй.

Тэрээр гурван хүүхдийн хамт амьдардаг бөгөөд том хүү Б.Алтан-Очир нь тус ангийн ахлагч. Ээждээ хэлэлгүй нэг л өглөө цэрэгт мордсон хүүгийнхээ сургийг гаргаж чадалгүй шар махтайгаа хатаж байх зуур, ангид нь томилогдон ирсэн шинэ цэргүүдийн тангаргийн баярын ширээний талх, нарийн боовны ажлаа ханцуй шамлан хийж байхад нь хүү тань дуудаж байна гэх дуудлагаар шинэхэн цэрэг хүүтэйгээ жагсаалын талбайд баярын нулимстай уулзаж байсан нь саяхан.

Хүү Б.Алтан-Очирын хувьд хүүхэд байхдаа хааяа хааяахан ээжийнхээ ангид ирэх бүртээ цэргийн хүн болох мөрөөдөлдөө хөтлөгдөн хажуугаар нь өнгөрсөн дүрэмт хувцастай цэргийн ах нарын оронд өөрийгөө төсөөлдөг

ч Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид хуваарилагджээ. За, ээжийгээ л энэ цэргийн ангид ажилладаг гэдгийг нь хамт алба хааж байгаа нөхдөдөө мэдэгдэхгүй юм шүү, эрхийн балай, ээждээ эрхлэх гээд ирсэн гэж бодно хэмээн ээждээ ч хэлэхгүй ээжийгээ хэсэг зовоосон түүхтэй. Цэргийн дүрэмт хувцсаар ижилдсэн олон арван цэрэг эрсээс ээж нь хүүгээ ялгаж олохгүйг тэр мэдэж байсан учраас тангаргийн баяр хүртлээ тас нуун гүрийчихсэн хэрэг. Ингэж ээж, хүү хоёрын нэг ангид алба хаах зам эхэлсэн аж.

Цагтаа хүүгээ цэргийн алба хаалгахгүй гэж байсан ээжийн бодол өдгөө эрс өөрчлөгдөж, миний хүүгийн сонголт зөв байсан төдийгүй цэргийн алба хүүг минь улам ухаалаг, эрдэм мэдлэгтэй, зөв хандлагатай эр хүн болгож өөрчилсөн дөө хэмээн бахархангүй хэлж байсан.

Хугацаат цэргээс ахлагч хүртлээ тус ангид алба хаах хугацаандаа ахлагч Б.Алтан-Очир хоёр удаа энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгээд амжсан бөгөөд Өмнөд Судан улсад үүрэг гүйцэтгэсэн цэргийн гэрээт алба хаагчдын анхдагчдын нэг юм. Хоёр охин дүүтэй, айл гэр авч яваа эрх хүний хувьд үүргээ маш сайн ухамсарлан нэг дүүгээ гадаадад их сургууль төгсгөөд амжсан мундаг ах гэдгийг нь орхигдуулж болохгүй. Түүний хүсэл мөрөөдөл, ирээдүйн төлөвлөгөөнийх нь талаар сонирхоход албаа нэр төртэй, үлгэр жишээч хаахын зэрэгцээ бага охин дүүгээ ч мөн гадаадад их сургуульд явуулах төлөвлөгөөтэй. Яагаад гэвэл дүү бид гурав өөр өөрсдийн сурсан, мэдсэн зүйлсийнхээ хэрээр эх орондоо ихийг хийх болно оо хэмээн даруухан агаад итгэл төгс хариулсан. Эх орныхоо төлөө гэх үийн л эрэлхэг хөвгүүнийг өсгөж, хүмүүжүүлсэн ижий танд болон Зэвсэгт хүчинд "баярлалаа" гэж хэлмээр ...

ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН ЗАЛГАМЖ ХАЛАА БОЛСОН ЗАЛУУ ҮЕИЙНХЭН ЯРЬЖ БАЙНА

Инженер сапёрын батальоны салааны захирагч, дэслэгч Э.ТҮВШИНТӨГС



Инженер болох багын мөрөөдлөө биелүүлж яваа дэслэгч Э.Түвшинтөгс 2017 онд ҮБХИС-ийг цэргийн инженер мэргэжлээр төгсөж тус ангид томилогдсон. Тэрээр салааны захирагч гэж хэн байх ёстойг үлгэрлэж явдаг нэгэн бөгөөд аюулгүй ажиллагаа, сургалтын талаар анхаарч ажилладаг гэнэ. Хичээлийн конспект, төлөвлөгөөг тухай бүрт нь шинэчлэн, орчин үеийн мэдээллээр баяжуулж, хугацаат цэргийн алба хаагчдадаа

заахыг хичээдэг. Хэчнээн мэддэг ч түүндээ бардаж болохгүй, хүнд юм зааж байгаа л бол суралцаар байх хэрэгтэй хэмээн ярих энэ хүн бол тус ангийн залуу боловсон хүчний төлөөлөл. "Би өөрийгөө Зэвсэгт хүчний шинэ үеийн төлөөлөл гэж боддог. Тийм ч учраас намайг бүтээн байгуулалтын ажил, энхийг сахиулах ажиллагаа гээд маш олон зүйлс хүлээж байгаа. Энэ ч үедээ илүү их зүйлийг сурч, улам илүү боловсрохыг хичээдэг" гэж тэр онцолсон.

Инженер сапёрын рот /ЦГАХ/-ын захирагч, ахмад Б.БУЯНДЭЛГЭР



Тэрээр цэргүүдээ удирдан Зэвсэгт хүчний 2013, 2015 оны марш тактик, тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож ангийнхаа нэрийг цуурайтуулсан Шилдэг офицеруудын нэг. 2016 онд Монгол Улсад зохион байгуулагдсан

"ASEM"-ийн дээд хэмжээний уулзалтын үеэр ротынхоо бие бүрэлдэхүүнийг удирдан "ASEM-Villa" хотхоны гадна тохижилтын ажлыг гүйцэтгэсэн юм. Мөн түүний удирддаг цэргийн гэрээт алба хаагчдын хувьд ихээхэн онцлогтой гэж хэлж болно. Тухайлбал, ихэнх нь тус ангид хугацаат цэргийн алба хаасан бөгөөд хэзээний танил болсон байх учир тэднийг инженерийн цэрэгт ойртуулах, мэргэшүүлэх тал руу түлхүү чиглэж ажилдаг гэнэ. Тиймээс л тус ангийн гэрээт цэргүүд бусдаас илүү хөдөлмөрч, хичээнгүй байж алба хаах хугацаандаа бүтээн байгуулагч цэргүүд болж чаддаг биз ээ.

Байлдагч А.АНХБАЯР

ШУТИС-ийн хоёрдугаар курсийн оюутан тэрээр гэрийнхнээс зөвлөсний дагуу оюутан цэрэгт явах гэж ирээд яриалт жагссан үе тэнгийн олон залуусыг хараад оюутан цэргийн хугацаа арай л чамлалттай санагдаад шууд л хугацаат цэргийн алба хаахаар шийдсэн гэдэг. Тэр шийдвэрээрээ өнөөдөр ийнхүү Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид алба хааж байгаа нь энэ. Алба хаах хугацаандаа 2019 онд "Төрийн далбааны өдөр"-ийн цэргийн ёслолын жагсаалд алхаж, Дорноговь аймгийн Сайншанд хотыг Газрын тосны үйлдвэртэй холбох хатуу хучилттай замын бүтээн байгуулалтын ажилд гар бие оролцсон бахархам, мартагдашгүй



дурсамжуудтай алба хааж байгаагаараа бахархдаг. Алба хаах хугацаандаа гэр лүүгээ нэг удаа чөлөөгөөр харьсан бөгөөд түүнийг ээж нь хурдан хөдөлгөөнтэй, авхаалжтай болсныг нь онцолсон бол харин охин дүү нь та асуултад ямар хурдан хариулаад байгаа юм бэ хэмээн шоолсон гэдгээ хуваалцаж байсан. Мөн тэрээр албаа хааж дуусаад ШУТИС-иа төгсөөд ҮБХИС-ийн цэргийн инженерийн ангид элсэн орох нэгэн шинэ зорилготой болсон гэдгээ энэ үеэр хэлж байсан. Магадгүй хэдэн жилийн дараа энэ л байлдагч инженерийн цэргийн мундаг офицер болсон байхыг үгүйсгэхгүй.

Нүүрийг бэлтгэсэн хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

ИРГЭН-ЦЭРГИЙН ХАРИЛЦАА ЭНД БЭХЖИЖ БАЙНА

Нийслэлийн хэмжээнд Цэргийн бүртгэл явагдаж байгаа энэ цаг үед Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын үйл ажиллагаатай танилцлаа.

Тус дүүргийн хувьд 1992 онд байгуулагдсан бөгөөд засаг захиргааны нэгжүүдийн удирдах албан тушаалтан, ажилтнууд нь харьцангуй тогтвор суурьшилтай ажилладаг гадна төрийн бодлогын залгамж сайтай гэж яригддаг. Энэ талаар тус дүүргийн Цэргийн штабын дарга, хурандаа Ж.Даваарагчаа хэлэхдээ "Манай хороодын дарга нар олон жилийн ажлын туршлагатай. Залуусыг сургаад л авчирдаг. Энэ нь төлөвлөсөн ажлыг чанартай гүйцэтгэхэд том хөшүүрэг болдог юм. Одоогоор Цэргийн бүртгэлийн үе тул тэд хэсгийн ахлагч нарынхаа ажиллах хуваарь, ажил үүргийн биелэлтэд нь хяналт тавих, өөрсдөө ч явцын мэдээ, тайлангаа боловсруулах гээд завгүй байх шиг байна. Жил бүрийн 1 дүгээр сард хийгддэг байсан цэргийн бүртгэл энэ жил хүн ам, орон сууцны улсын тооллогоос шалтгаалан арай хожуу явагдлаа. Иргэдийн бүртгэлийн ирц, идэвх жилээс жилд сайжирч байна. Энэ нь үүргээ тодорхой хэмжээнд ухамсарлаж буйн шинж юм. Бас байнгын мэдээлэлтэй байна. Цэргийн бүртгэлийн ирц 90 гаруй хувьд хүрэх төлөв ажиглагдлаа" гэв. Хурандаа Ж.Даваарагчаа



Хурандаа Ж.ДАВААРАГЧАА

2017 онд ажлын үзүүлэлтээрээ Нийслэлийн хөдөлмөрийн аварга болж байсан бол Цэргийн штаб нь сүүлийн жилүүдэд ажил үйлсээрээ тогтмол тэргүүлж, мөн онд "Аймаг, нийслэл, дүүргүүдийн цэргийн штабын үнэлэх журам"-ын дагуу Батлан хамгаалах яамны шалгалтад "Бүрэн хангалттай" шалгагдсан зэрэг баялаг амжилттай хамт олон юм.

Чингэлтэй дүүрэг нь 19 хороотой. Аливаа нэгэн ажлыг зохион байгуулахдаа хороод, хэсгийн ахлагч нарынхаа дунд уралдааныг зарлаж тодорхой хэмжээнд урамшуулж, шагнадаг хэлбэр рүү шилжсэн нь ажлын бүтээмжийг дээшлүүлэхэд бодитой нөлөө үзүүлсэн байна. Түүнчлэн хороо бүр 18 нас хүрсэн иргэддээ цэргийн үүрэгтний үнэмлэхийг нь ёслол төгөлдөр гардуулж өгдөг аж. Ингэснээр тухайн иргэнд цэргийн албыг сурталчлахаас гадна үнэ цэн, ач холбогдлыг нь бага ч атугай мэдрүүлдэг гэж цэргийн бүртгэлд хамрагдсан залуус онцолж байлаа.

Монгол Улсын Засгийн газраас "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг баталсан билээ. Үүний хүрээнд Чингэлтэй дүүргийнхээ Ерөнхий боловсролын 12 сургуулийн 3000 гаруй сурагчдад яриа таниулга хийж, хэвлэл мэдээллийнхний тусламжтайгаар олон сувгаар мэдээллээ түгээжээ. Төвийн дүүрэг учраас хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй их ойр ажилладаг онцлогтой. Энэ ч утгаараа



Ж.ЭРДЭНЭБАТ

аливаа нэг үйл ажиллагааны ард хэвлэлийнхэн үргэлж бэлэн. Мөн "Соёмбо" сонин, "Дуулга" студитэй хамтарч ажилладаг. Дээрх хөтөлбөрийн хүрээнд ЗДТГ болон Боловсролын хэлтэстэй хамтран "Эх орноо магтан дуулъя" дууны уралдааныг зохион байгуулж эхний 10 байрт шалгарасдыг шагнаж, урамшуулсан" гэдгийг хурандаа Ж.Даваарагчаа онцлоод ЗДТГ-ын зүгээс Цэргийн штабын ажлыг их ойлгож, дэмждэгээс гадна Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас тухайн жилдээ дэвшүүлсэн зорилго, зорилгудтайгаа уялдуулан, удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангасаар ирсэн нь амжилттай ажиллах хөшүүрэг болдог гэлээ.

Чингэлтэй дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбат Хилийн цэргийн ангид гурван жилийн хугацаат цэргийн алба хаасан бол ЗДТГ-ын дарга А.Дамцагдоржийн хувьд ҮБХИС-ийг цэрэг, улс төрийн ажилтнаар төгссөн, анги, байгууллагад олон жил ажилласан туршлагатай. Тэд бэлтгэл хурандаа цолтой. Тиймдээ ч Цэргийн штабынхаа үйл ажиллагааг ойлгож, дэмжих тал дээр хэнийг ч дагуулахааргүй гэдэг нь мэдрэгдсэн.

Чингэлтэй дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбат хэлэхдээ "Цэргийн албанаас эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн залуусыг хяналтад авч байгаа. Мөн цэргийн насны залуусын эрүүл мэндийг сайжруулах хүрээнд хороодын Засаг дарга нар ажлын алба, өрхийн эрүүл мэндийн төвүүд, цэрэг татлагын нарийн мэргэжлийн эмч болон Ерөнхий боловсролын сургуулиудын захирал, эмч нарын дунд болзолт уралдааныг зарладаг болсон. Оны эцэст дүгнэн эрүүлжилтийн түвшин, гүйцэтгэлийнх нь тайлантай танилцаад тодорхой хэмжээний шагнал, урамшуулал олгодог. Өнгөрсөн жил эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй учраас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч чаддаггүй, амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур 300 гаруй цэргийн насны залуучууд бий гэсэн судалгаа гарсан юм. Тэдгээр иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулахын тулд Засаг даргын нөөц хөрөнгөөс 10 гаруй сая төгрөгийг гаргуулсан. Эрүүл мэндийн даатгуулагч нь сардаа 3200 төгрөг, жилдээ 38400 төгрөг төлдөг. Энэ асуудлыг бүрэн шийдвэрлэснээр тэдгээр залуус эмнэлгийн тусламж, үйлчилгээг авах боломж бүрдсэн гэж болно" гэв.

Чингэлтэй дүүргийн хувьд цэрэг, спортын "Дөл" тэмцээнд жилээс жилд ихээхэн ач холбогдол өгч ирсэн. Энэ талаар ЗДТГ-ын дарга А.Дамцагдоржоос тодруулахад "Манай дүүрэг бусад дүүргээс ялгаатай нь тус тэмцээнд анги хамт олноор нь оролцуулж, салаа болгож бэлддэг. Тодруулбал, анги

дүүргэлт, сурагч бүрийн оролцоог чухалчилдаг. Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг Ерөнхий боловсролын ахлах ангитай нийт 12 сургууль тус бүрийг нэг салаагаар тооцож 30 ширхэг хуучны цэрэг шар ногоон иж бүрэн хувцас, мөрдэс, малгай, тэмдэг, бүсээр хангалаа. Ингэснээр тулгарад байсан хувцасны жигдрэлтийн

асуудлыг шийдэж сургуулийн ачааллыг хөнгөвчилж чадсан, дүүргийнхээ хэмжээнд 360 хүүхэд жигдэрсэн. Мөн тэмцээний үр дүнгээр сургуулиудын материаллаг баазыг бэхжүүлэх хүрээнд стандартын бөмбөр, лед дэлгэц зэргийг авч өгснөөр зарим асуудлыг нь шийдвэрлэсэн. Харин сүүлийн жилүүдэд сурагчид руугаа хандаж эхний



А.ДАМЦАГДОРЖ

хоёр байр эзэлсэн анги, хамт олныг анги удирдсан багштайгаа ОХУ, Улаан-Үд хот руу аялах эрхийн бичгээр шагнаж урамшуулдаг болсон" гэсэн юм.

Энд нэг зүйлийг онцлоход, аяллын явцад иргэн-цэргийн харилцаа жинхэнэ утгаараа бүрэлддэг аж. Тухайлбал, Дархан-Уул, Сэлэнгэ аймагт байрлах цэргийн ангийн үйл ажиллагаатай сурагчдаа танилцуулж, эх орон, тусгаар тогтнолын үнэ цэнийн талаар яриа таниулга хийж, уулзалт зохион байгуулдаг гадна Хилийн цэргийн ангиудаар ч зочилдог байна. ОХУ-д очих унаа, байрлах байр гээд ер нь "Дөл" тэмцээний зохион байгуулалт, шагналд 20 гаруй сая төгрөг зарцуулагддаг аж.

Хамгийн гол ач холбогдол нь анги, хамт олны эвсгэр уур амьсгал, гар нийлэмжтэй ажиллагаа, бие бялдрын үзүүлэлтүүд, аливаад хандах хандлага, гүйцэтгэх чанарууд дээшилж байдаг оршдог аж. Нийлбэр дүнгээс гадна төрөл тус бүрт байр шалгаруулдаг учраас шагналын сан өндөртэй. Үүнд сурагчид их урамшиж, намар хичээлийн шинэ жил эхлэхээс л тэмцээндээ бэлддэг нь тухайн тэмцээний чанар чансаа мөн сурагчдад цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж буйг илхнээ хэлээд өгнө.

Биднийг ийн ярилцаж суух зуур зургаадугаар хорооны Засаг дарга Ч.Болормаа яаран гүйсээр орж ирэв. Өөр хэд хэдэн хүн ч байсхийгээд л хаалга тогшино. Зөвхөн өнөөдөр ч гэлтгүй өдөр бүр ингэж өнгөрдөг гэхэд хилсдэхгүй аж. Цэргийн ангид цэргийн дүрмээр бүх зүйл зохицуулагддаг бол энд арай өөр дүр зураг ажиглагдсан. Хөгшин, залуу, эрэгтэй, эмэгтэй гээд янз бүрийн хүмүүс л орж гарцгаана. Тэр бүрт хурандаа Ж.Даваарагчаа мэдээллээр хангаж, асуудал байгаа бол гаргалгааг нь хэлж, хуулийн үүднээс тайлбарлаж өгөөд


явуулна. Энэ зан чанар нь түүнийг харилцааны боловсрол, соёлд суралцсан хүн гэдгийг нь батлан харуулж, иргэд ч "баярлалаа" гэдэг үгээр хариу барина лээ. Олон хүнтэй харилцсан, эргэх холбоо үүсгэсэн, талархлын үгс дүүрэн энэхүү цэргийн штабт жинхэнэ иргэн-цэргийн харилцаа бэхэждэг юм байна гэсэн бодол өөрийн эрхгүй төрж байсныг энд тэмдэглэх нь зүйтэй байх.

Зургаадугаар хорооны Засаг дарга Ч.Болормаа цэргийн бүртгэлийн талаарх явцын мэдээ өгснийхээ дараа цөөн хором ярилцаад мөн л яарсаар гарч одов. Цаг баримталдаг герман соёл түүний унаган зан ажээ. Тэрээр төрийн албанд 23 дахь жилдээ ажиллаж байгаа. Хорооныхоо иргэдийн нэвтэрхий толь болсон Засаг дарга Ч.Болормаа "Манай Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабынхан жинхэнэ мэргэшсэн баг. Энэ нь мэдээж хурандаа Ж.Даваарагчаагийн удирдах арга барил, төлөвлөлт, зохион байгуулалттай холбоотой" гэв. Үнэхээр ч дан ганц түүний хэлсэн үг гэлтгүй бусад хорооны Засаг дарга нар ч дээрхтэй адил утгатай зүйл хэлж байв. Энэ талаар хожим өгүүлэх болно.

Чингэлтэй дүүргийн Цэргийн штабаас албан тушаалтны болон томилгоот бүрэлдэхүүний сургалтыг штабын дадлага хэлбэрээр тодорхой цагийн байдал үүсгээд дайчилгааны татан нийлүүлэх төлөвлөгөөний дагуу тухайн хороод хэчнээн хүн, техник гаргах боломжтой гэдгийг судалж, тооцоо, өгөгдөхүүнийг бодуулж, өөрсдөөр нь илтгүүлдэг. Ингээд хороодын Засаг дарга нарынх дууссаны дараагаар ажлын албаны дарга нар, зохион байгуулагч зэрэг гүйцэтгэх албан тушаалтнуудтай нэг ижил хөтөлбөрөөр тус сургалтыг явуулдаг байна. Ингэхдээ хүн нэг бүрийг хэзэрийн хувцсаар хангасан бөгөөд бусад үед ч хэрэглэхэд тун тохиромжтой аж. Тухайлбал, цэргийн бүртгэл, цэрэг татлага болон бусад тэмдэглэлт өдөр, ойн баяраар та үүнийг харж болно. Нутаг дэвсгэрт нь Зэвсэгт хүчний анги байдаггүй ч Онцгой байдлын газар, Цагдаагийн хэлтэс, Улаанбаатар цэргийн хүрээний болон бусад алслагдсан ангитай байнгын хамтын ажиллагаатай байж сургалт, дадлагыг тогтмол зохион байгуулахдаа давхар нийгмийн хариуцлагын хүрээнд ч тодорхой ажлуудыг хэрэгжүүлдэг. Тухайлбал, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ойжуулах, сургуульд оролцсон цэргийн үүрэгтнүүдийг урамшуулах, анги, байгууллагын материаллаг баазад дэмжлэг үзүүлэхээс гадна зарим алба хаагчийн нийгмийн асуудалд анхаарлаа хандуулан зургаан хүнд гэр олгож, мөнгөн тусламж үзүүлэх. Мөн Цэргийн штабаас цэргийн баярын өмнө Зэвсэгт хүчинд болон Хилийн цэрэгт хугацаат цэргийн албаа хааж байгаа амьжиргааны түвшин доогуур, эмчилгээ, үйлчилгээ шаардлагатай зургаан түрүүч, байлдагчийн ар гэрт мөнгөн тусламж үзүүлсэн зэргээр албаа сэтгэл хоёрдолгүй хаах нөхцөлийг нь бүрдүүлж өгсөөр иржээ. Энэ мэтчилэн уламжлал болсон ажил цөөнгүй бий. 2019 онд ажлын биелэлтийн төлөвлөгөөгөө бүрэн хангасан тус хамт олон 2020 онд орон нутгийн хамгаалалтын нэгжийн удирдлагын бүрэлдэхүүний сургалт, штабынхаа хэргийн бэлтгэлийг одоогийн түвшнээс ахиулахад илүүтэй анхаарч байгаа бөгөөд шаардагдах зүйлсийг хэдийнээ бэлдэж эхэлсэн байна.

Тус цэргийн штабын хамт олон даргынхаа өгсөн үүрэг чиглэлийн дагуу дор бүрнээ ажилдаа мэрийж толгой өндийх завгүй сууцгаана. Ийм нэгэн дүр зураг ажиглагдах эгшинд тоо бүртгэлийн офицер, дэд хурандаа Н.Сүхбаатар "Цаг дөхсөн байна. Одоо хороодоор орж цэргийн бүртгэлийн ажлын явцтай танилцана" гээд гарч одов. Дэд хурандаа Н.Сүхбаатар 2012 оноос энэхүү Цэргийн штабт ажиллаж байна. Түүнээс хамааралгүй ажил гэж үгүй. Аливаа ажилд тоо бүртгэлийн

офицерын үүрэг, оролцоо өндөр байдаг аж. Тэрээр 1998 онд ЦИС-ийг Ерөнхий цэргийн команд штабын мэргэжлээр төгссөн.



Дэд хурандаа Н.СҮХБААТАР

Түүнээс хойш Зэвсэгт хүчний ангиудад алба хааж байгаад 2007 онд БНХАУ-ын Хуурай замын механикжуулсан мотобуудлагын ротын захирагчийн дамжааг, 2010 онд БНТУ-ын Хуурай замын цэргийн офицерын анхан шатны дамжааг тус тус төгсөж мэргэжил, ур чадвараа ахиулжээ. Түүнтэй уулзсанаар цэргийн штабын үйл ажиллагааны талаар зарим хорооны Засаг дарга нарын сэтгэгдлийг сонсох завшаан тохиосон юм. Тэрээр цэргийн бүртгэлийн явцтай танилцах ажлаа нэгдүгээр хорооноос эхлүүлээ.

Тус хорооны Засаг дарга, Чингэлтэй дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч Н.Сайнболд "Миний хувьд жил бүрийн цэрэг татлага, цэргийн бүртгэлийн үеэр дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу ажлын албаа мэргэжил, арга зүйгээр хангаж ажилладаг. Энэ жилийн цэргийн бүртгэлийн хувьд өмнөх жилүүдийнхээс илүү өндөр зохион байгуулалттай явагдаж байгааг хэлэх нь зүйтэй байх. Мэдээж, цэргийн штабынхангүйгээр энэ ажлын ард гарч чадахгүй. Одоогоор тоо бүртгэлийн мэдээгээ тухайн өдөрт нь явуулж, иргэдийг мэдээллээр хангаж байна. Хороод цэргийн штабтайгаа тухайн жилд хамтран ажиллах гэрээ байгуулаад хэрэгжүүлж байгаа ажилд нь хуулийн дагуу оролцдог. Үүний нэг нь хороодын Засаг дарга нартай явуулдаг цэргийн бэлтгэл үүрэгтний сургалт. Ер нь сургалтуудын ач холбогдол, үр дүнгийн тухай сэтгэл хангалуун байдаг. Учир нь тухайн орон нутгийг удирдаж байгаа албан тушаалтан бүр зайлшгүй сурч, мэдэх ёстой ур чадвар, мэдлэгийг олж авдгаараа өндөр ач холбогдолтой санагдсан. Мөн бэлтгэл офицеруудыг хувцаснаас гадна аранзаар хангаж өгсөн явдалд талархаж байгаагаа илэрхийлнэ. Сүүлийн жилүүдэд цэргийн насны залуусын эрүүл мэндийн асуудал анхаарал татах болсон. Энэ чиглэлээр өрхийн эрүүл мэндийн төв, хорооны Засаг даргын ажлын алба хамтраад өвчлөлтэй иргэдийг эмчийн хяналтад байлгах, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, хороодын дунд болзолт уралдааныг зарлах гээд Цэргийн штабаас үр дүнтэй ажлуудыг хэрэгжүүлсээр байгаа" гэлээ.

Дараагийн хороо бол гуравдугаар хороо. Энэхүү хорооны хувьд хүн амын нягтаршил ихтэйгээс гадна олон тооны бэлтгэл, офицер ахлагч байдгийг Засаг дарга С.Туяа онцлоод амжив. Тэрээр "Цэрэг татлага, цэргийн бүртгэл болон бусад Батлан хамгаалах хууль тогтоомжийн хүрээнд хийгддэг ажлуудад дүүргийн Цэргийн штабаас өдөр тутам бидэнд заавар, зөвлөгөө өгдөг. Ажлын гүйцэтгэлийн явцад ямар нэгэн бэрхшээл тулгардаггүй нь Цэргийн штабын барьж буй бодлого, төлөвлөлттэй шууд холбоотой. Цэргийн насны залуусын эрүүл мэндийг сайжруулах, өвчлөлийг нь бууруулах аяны хүрээнд иргэдийг үзлэгт хамруулдаг. Шаардлагатай тохиолдолд өрхийн эмнэлэгтэй нь холбож, дараагийн шатлалын эмнэлэгт хандсан иргэдтэй байнгын эргэх холбоотой ажиллаж байна. Ингэснээр залуусын өвчлөл мэдэгдэхүйц буурсан. Харин өөрсдийнх нь үүрэг, оролцооноос иш зүйл шалтгаалдгийг иргэд сүүлийн үед ойлгож, ухаардаг болсон. Энэ нь өнөөдрийн цэргийн бүртгэлийн ирцээс харагдаж байна" гэлээ.

Ц.ЭНХ-ОРГИЛ



Хороодын Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалт

Миний бие 1952 онд Сэлэнгэ аймагт өнөр өтгөн ам бүлд төрсөн. Намайг өргөж авсан аав Төгөөгийн Ганжуур орон нутаг дахь их жанжны хамгийн ойрын ясан төрлийх нь садан хүн юм. Аавын маань аав Хар толгой хэмээх Самдан нь их жанжны аав Дамдины эгч Тамзавын ач хүү бөгөөд аав, жанжин хоёр төрсөн эгч, дүүсийн хүүхдүүд юм.

Аав маань 1952 онд нутгийн хэсэг уяачдын хамт улсын наадамд ирж түүний уясан морь гуравт хурдалсныг жанжны хүү С.Галсангийнхаа нэр дээр цоллуулаад нөхдөөсөө хоцорч үлдсэн ба С.Янжмаа, С.Галсан нарт хүүхэд үрчилж авах тухайгаа хэлсэн гэдэг. Тэр үед С.Янжмаа Намын төв хороонд, С.Галсан Батлан хамгаалах яаманд өндөр алба хашиж байсан юм билээ. Энэ тухай “Соёмбо” сонины сурвалжлагч асан дэд хурандаа Г.Баатарнум “Жанжны голомтод үрчлэгдсэн хүү” нэртэй өгүүлэл бичиж байлаа.

Би бээр оюутан ахуй насаа жанжны хүү С.Галсан, түүний охин С.Нарангийн амьдарч өнгөрүүлсэн. Тэр үед С.Галсан ахынд Ардын хувьсгалын партизан Д.Дашзэвэг, Мягмар, БНМАУ-ын баатар Л.Дандар, Ж.Лхагвасүрэн, Д.Данзанваанчиг, С.Дампил, Ш.Гонгор, нам, төрийн нэрт зүтгэлтэн Б.Ширэндэв, Л.Моломжамц, Б.Алтангэрэл зэрэг нэр цуутай хүмүүс ирж хууч хөөрөгддөг байв.

С.Галсан ахынх тэр үед “40 мянгатын Ямбатны ягаан” хэмээн нэрлэгдсэн байранд Б.Ширэндэв, Б.Алтангэрэл, нэрт дипломатч Балжинням, хошууч генерал Д.Вавуу нартай хөрш байсан юм. Ах маань С.Наран, Т.Амгалан гэсэн хоёр охинтой Г.Сүхбат, Г.Алтансүх гэсэн хоёр хүүтэй. Ахын охин, Гадаад явдлын яамны сайд М.Дүгэрсүрэнгийн гэр бүл С.Наран маань бидэндээ өмөг түшиг болж үнэт сургаалаа хайрласаар яваа буурал бөгөөд өдгөө энх тунх байна.

Ер нь эрдэмтэн, Сүхбаатар судлаач, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор О.Пүрэв гуайн судалснаар жанжны төрөл төрөгсөд болох 200 гаруй хүн нийслэл хот болон Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Орхон, Дархан-Уул аймагт амьдарч байна. Энэ тухай Монгол Улсын гавьяат багш С.Лувсанноров гуай тодорхой бичсэн байдаг юм. Би эдгээр нөхдөө төлөөлөн тухайн үеийн Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдод өргөдөл бичиж Нийслэлийн төв талбай дахь жанжны хөшөөг хүрэл болгох санхүүгийн асуудлыг нь шийдвэрлүүлсэн ба БНХАУ-ын Бээжин хотноо миний дүү, нэрт барималч А.Очирболд тэргүүтэй уран бүтээлчид шинэчлэн, гоёмсог болгосноор бид нээлтэд нь оролцож байлаа. Өдгөө хуучин хөшөө нь Дундговь аймагт Зава Дамдины хийдэд байрлаж байна.

Энд түүх өгүүлэхэд, би бээр ах С.Галсан болон аав Т.Ганжууртайгаа олон түүхт үйл явдал, уулзалтад урилгал оролцож байсан юм. Үүнээс хамгийн



дурсамжтай нь, жанжны нэрэмжит Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумыг “Гүн булаг” хэмээх газарт байрлаж байхад 1961 онд тэнд босгосон Д.Сүхбаатарын цээж баримал хөшөөний суурийг тавихад аавтайгаа хамт алд цэнхэр хадаг, дугуй булантай цай тэргүүтнийг тавьж байснаа тод санадаг юм.

Манай нутагт жанжны нэртэй холбоотой “19-ийн хонхор” болон ард түмэнтэй уулзсан газар нь босгосон хүндэтгэлийн багана, ээж Хандынх нь нэртэй худаг, аав, ээжийнх нь нутаглаж байсан Хайлааст үүдэн, Ёст бэйсийн хошуу зэрэг газруудыг нутгийн зон олон ихэд хүндэлдэг юм.

Д.Сүхбаатар Ардын хувьсгалын дараахан аав, ээжийнхээ нутгаар дамжин өнгөрөхдөө хошуу ноёныхоо бэлэглэсэн ембүүг буцаан өгч, орон нутагтаа сургууль байгуулаарай гэсэн юм билээ. Энэ тухай би “Жанжны бэлгийн сургууль” гэсэн номондоо тодорхой өгүүлсэн юм.

Би бээр “Их жанжны нутгийн урлаг, соёлын авьяастнууд”, “Их жанжны нутгийн цагдаагийн байгууллага”, “Жанжнаар овоглосон сум”, “Жанжны нутгийн Онцгойгийнхон” зэрэг 10 шахам ном бичсэн бөгөөд харамсалтай нь зарим номоо хөрөнгө, санхүүгийн шалтгаанаар хэвлүүлж чадахгүй л явна.

Сүхбаатар судлаачид, эрдэмтэд, ах дүүтэйгээ хамгийн ойр байдаг болохоор жанжны тухай олон дурсамжийг тэднээсээ сонсож байлаа. С.Галсан ах ч аавыгаа бурхны оронд залрахад хүүхэд байсан болохоор тодорхой зүйлийг дэлгэрэнгүй ярьдаггүй ч ахмад партизанууд болон Сүхбаатар судлаачдаас дуулж сонссоноо надад байнга ярьдаг байсан юм.

1993 онд Д.Сүхбаатарын 100 жилийн ойгоор төрөл төрөгсөд нь болох 20 гаруй хүн ирж тэрхүү ойн ёслолд оролцож жанжны төрсөн гэрийн буурин дээр нь очин хүндэтгэл үзүүлж байсан нь саяхан мэт санагдана. Тэр үед би Монгол Улсын Соёлын яаманд ажиллаж байсан юм. Миний бие зохих шатны сургуулиудыг төгсөөд орон нутаг

Г.Энхтайван: ДУРСАМЖ ЯРИА ИХ БИЙ

дахь соёл, боловсрол, залуучуудын байгууллага, тэр үеийн НАХЯ-ны цэргийн дээд сургууль /одоогийн Дотоод хэргийн их сургууль/ болон Соёлын яаманд алба хашиж байлаа.

Жанжны маш их судалсан хүн бол доктор О.Пүрэв, Л.Дашдаваа, С.Лувсанноров, О.Баатар, Б.Эрдэнэсүрэн нар гэдгийг манай уншигчид сайн мэдэх биз ээ. О.Баатар гуайн цуглуулсан гэрэл зураг, ордон, медаль, түүхт ойгоор нь гаргасан дурсгалын тэмдгүүдээр нь “Тусгаар тогтнолын ордон”-ы хоёрдугаар давхарт үзэсгэлэнг дэлгэж нийтийн хүртээл болгож байна.

Жанжин Д.Сүхбаатар 1922 онд Зүүн хязгаарыг эргэх ажлын далимаар өөрийн аав, ээжийнхээ нутгаар орж хошуу ноён Доржавын хүүгийн болон манай өвөөгийн тус тус нэг хоносон юм гэнэ лээ. Энэ үедээ өвөөд маань өгсөн жанжны аав, ээжийн голомтын тулгыг нь би улсын музейд, аавынхаа эдэлж хэрэглэж байсан эд өлгийн зүйлсийг орон нутгийнхаа музейд хадгалуулсан юм.

Харин 1992 онд Сүхбаатар аймгийн 50 жилийн ойн баяраар нэрт барималч Г.Дандиймаагаар Д.Сүхбаатар, С.Янжмаа нарын хамт авахуулсан отго жинсэн малгайтай гэрэл зургаар нь баримал хийлгэж орон нутгийн музейд хадгалуулсан нь манай улсын ямар ч музейд байхгүй үзмэр болсон гэж боддог.

Энд сонирхуулахад, Д.Сүхбаатар одоогийн бидний ярьж заншсан “Жанжин малгай”-г өмсөж үзээгүй юм гэнэ лээ. Манай нутгийн зураач Ядамсүрэн гуай л жанжны гоё харагдуулах гэж тэрхүү малгайг зохиомжлон зурсан ажээ. Жанжин отго жинстэй, саравчтай, тоорцог хэлбэртэй малгай л өмсөж байсан нь түүхэн үнэн юм. Үүнээс тоорцог хэлбэртэй цэмбэн малгайг гэхэд л улаач байхдаа өмсөж байсан жишээтэй. Би ах, дүүсээсээ гадна их жанжны дүрийг гайхамшигтай бүтээсэн Монгол Улсын гавьяат жүжигчин Ц.Дашнамжил гуайтай их дотно үерхэж байлаа.

С.Галсан ах нэг өдөр над руу утасдаад “Урьд шөнө аав маань бурхан болчихлоо” гэхэд нь би гайхаад очтол “Дашнамжил өнгөрчихөж, миний хүү ажил явдалд нь оролц” гэснээр би хань ижил, үр хүүхэдтэй нь ярилцан “Жанжны дүрээр тань Монголын ард түмэн мэднэ” хэмээн хөшөө чулуун дээр нь бичүүлж билээ.

Намайг үрчилж авсан аав Т.Ганжуурыг нутгийн зон олон жанжны

ойрын садан төрлийн хүн, “Нэрт уургач, эмнэг сургагч” гэж хүндэлж намайг хүртэл малын докторын хүү гээд өхөөрдөн ундаалж, цайлж, тэр үеийн айлд байсан ганц орон дээрээ унтуулдаг байлаа. Одоо ч намайг болон миний үр хүүхдүүдийг нутгийнхан маань их хүндэлдэг. Миний том хүү Э.Мөнхтөр Говьсүмбэр аймаг дахь Төмөр замд, охин Э.Мөнхзул Боловсрол, соёлын төвд, удаах хүү Э.Мөнх-Оргил Зэвсэгт хүчний Жанжин штабт, Э.Баянмөнх Шүүхийн шинжилгээний хүрээлэнд ажиллаж өвөө болон аавынхаа нэр төрийг өндөрт өргөж яваад нь баярлаж явдаг юм.

Дашрамд, Нэмэндэйн Янжмаа эмээ манай нутгийн хүн бөгөөд намайг үрчилж авахад их үүрэг гүйцэтгэсэн юм билээ. Эмээ, аав хоёр маань хүүхэд үрчлүүлэх айл хайж байгаад нэг өдөр манайд ирсэн юм гэсэн. Тэгээд долоо хоногийн дараа нэг том эр хонь, бэлэг сэлттэй ирээд намайг явч явсан гэдэг. Энэ тухай миний ээж Х.Чойжинзав өгүүлэхдээ “Янжмаа дарга, өвгөнийхөө дүүг дагуулж ирээд хүүг маань аваад явсан. Би чинь хүүгээ нэг эр хониноос өгчихсөн юм” гээд хөхөрдөг сөн.

Янжмаа эмээгийн тогооч асан солонгос хүн намайг угж хөхүүлж сургаад 11 дүгээр сард Сүхбаатар аймаг руу явуулсан гэсэн. Миний том эгч Туулын охиныг нэрт орчуулагч, дипломатч Ц.Наваан-Юндэн гуай өргөж авсан нь бас сонин шүү. Ц.Наваан-Юндэн ах Д.Нацагдоржтой хамт Герман улсад хамт сурч байсан юм билээ. Тэрээр “Баянмонгол”, “Соёл-Эрдэнэ”, “Үхэрчин хүү Цэрэндорж” зэрэг дууны үгийг зохиосон том зохиолч, их гүүш, орчуулагч юм.

Жанжны 100 жилийн ойн өмнөхөн доктор О.Пүрэв, УИХ-ын гишүүн Ш.Бадам, УГЖ Ц.Дашнамжил зэрэг нөхөдтэй Сүхбаатар аймагт долоо хоногийн томиллолтоор ажилласан юм. Тэр үеэр доктор О.Пүрэв гуай их сонирхолтой зүйл ярьж өгдөг байлаа. Бид аймагт Сүхбаатар нэртэй 50 орчим хүнийг цуглуулан бэлэг сэлт өгч, сумдаар явж уулзалт зохион байгуулсан юм. Тэр үед хамгийн хүндтэй зочин бол Ц.Дашнамжил гуай байлаа. Биднийг айлд орохоор л “Жанжин ороод ирлээ” гээд л сүйд болдогсон. Тэгэхээр жанжны дүрийг мань эр үнэхээр гайхамшигтай бүтээжээ. Ц.Дашнамжил гуай уран сайхны долоон кино, дуурийн гурван бүтээлд жанжны дүрд тоглосон чадварлаг жүжигчин байсан юм.

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ

СТАНДАРТЧИЛАЛ БА СТАНДАРТЫН ҮНДСҮҮД

ОРШИЛ

ЗХЖШ-ын даргын 2016 оны А/454 дүгээр тушаалаар Зэвсэгт хүчний Цэргийн стандартын техникийн хороо байгуулах тухай шийдвэр гарсан ба өдгөө Зэвсэгт хүчний Ерөнхий хянан шалгагч, ХШҮГ-ын дарга, бригадын генерал П.Доржсүрэнгээр удирдуулсан Цэргийн стандартын техникийн хороо үйл ажиллагаагаа явуулж байна.

Цэргийн стандартын техникийн хороо нь улсын стандартыг шинээр боловсруулах, хянаж шинэчлэх санал оруулах, олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартыг орчуулж үндэсний болгох, байгууллагын стандартыг хэлэлцэн батлах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулан хэрэгжүүлж байна.

Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд цэргийн сургалт бэлтгэл, цэргийн мэргэжлийн боловсролын стандарт, барилга, тээвэр, холбоо, хүнс, хувцас, шинжлэх ухаан, техник, хүн, мал эмнэлэг, техник, тоног төхөөрөмж, шинжилгээний арга, баримт бичиг, хэмжил зүйн техник болон хэмжих аргын олон зуун стандартууд хэрэглэгдэн мөрдөгдөж байна.

Стандартчилал, үндэсний ба байгууллагын стандарт, олон улс, бүс нутгийн стандарт, дэвшилтэт техник, технологийн стандарт, стандартчиллын тогтолцоо, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай асуудлыг “Соёмбо” сонинд цуврал болгон нийтэлж Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүд стандарт ба стандартчиллын тухай мэдлэг олгох болон ажил, үйлчилгээ, үйл ажиллагаандаа хэрэглэх, практик дадлага эзэмшүүлэх зорилтыг дэвшүүлж байна.

НЭГ. СТАНДАРТЧИЛЛЫН ҮНДСЭН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЗАРЧИМ, ҮҮРЭГ, ТОГТОЛЦОО ЗҮЙЛ, ШАРДЛАГА

Бүтээгдэхүүн, үйлчилгээ, ханган нийлүүлэгч талуудын хооронд

тохиолддог зөвхөн нэг асуудлыг хэлэлцэхэд олон төрлийн боломжит санаанууд гардаг. Энэхүү хэлцлийг стандартчилснаар зохицуулалт нь илүү хялбар ойлгомжтой болж, өргөн хүрээнд үйлчилдэг.

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэрэглээний тохиромжтой байдал, харилцан орлуулалт, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдаагнэмэгдүүлэх, хэмжлийннэгдмэл байдлыг хангахад стандартчиллын үндсэн зорилго нь оршино.

Стандартыг үндэсний аюулгүй байдал, хүрээлэн буй орчин, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэндийг хамгаалахын тулд хэрэглэж мөрдөнө.

Стандарт нь аливаа зүйлийг харьцуулахад хэрэглэдэг жишиг бөгөөд бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үзүүлэлт, шаардлагын хэм хэмжээ, харилцааг зохицуулагч нь болдог.

Стандартчилал ба стандартгүйгээр улс орны болон олон улсын худалдаа, үйлдвэрлэл, ажил үйлчилгээ, бизнес хөгжих боломжгүй юм.

1.1.Стандартчиллын үндсэн зорилго, зорилтууд:

Стандартчиллын үндсэн зорилго нь бүтээгдэхүүний хэрэглээний нийцтэй байдал, харилцан орлуулалт болон сорилт, хэмжилтийн нэгдмэл байдлыг хангах замаар нөөцийг зүй зохистой ашиглах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Стандартчиллын зорилтууд:

- Үйлдвэрлэл, хөдөлмөрийн бүтээмж, инженерчлэл болон удирдлагыг боловсронгуй болгон үр дүнг дээшлүүлэх, техникийн дэвшлийг хурдасгах;
- Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, түүнийг үр ашигтай түвшинд хүргэх;
- Улс орныг хэрэгцээт бүтээгдэхүүнээр тавигдах шаардлагын дагуу хангах;
- Дэлхийн зах зээлийн шаардлагыг хангасан дээд чанартай бүтээгдэхүүнээр гадаад худалдаа хийх нөхцөлийг бүрдүүлж хөгжүүлэх;

➢ Зах зээлийн эдийн засгийн удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

➢ Бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон зохион бүтээх байгууллагыг мэргэшүүлж хөгжүүлэх;

➢ Хөдөлмөрийн нөөц, материалыг хэмнэх болон үйлдвэрлэлийн нөөцийг үр ашигтай ашиглах;

➢ Ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах;

➢ Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах ажил, үйлчилгээний чанарыг сайжруулах;

➢ Олон улсын эдийн засаг, техникийн хамтын ажиллагааг өргөжүүлэх.

1.2.Стандартчиллын зарчим:

➢ Нийгмийн эрх ашигт нийцэх;

➢ Бие даасан хараат бус байх;

➢ Төр, үйлдвэрлэгч, хэрэглэгч тэгш эрхтэйгээр оролцох;

➢ Стандарт нь шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн түвшинд практикийн ололтод тулгуурласан товч тодорхой агуулгатай байх;

➢ Олон улсын стандартыг үндэсний стандартыг боловсруулахад үндэс суурь нь болгох;

➢ Стандарт нь үйлдвэрлэл, худалдаанд үндэслэлгүйгээр саад учруулахгүй байх;

➢ Стандарт нь бүтээгдэхүүний хэрэглээний болон ашиглалтын шинж чанарт үндэслэх;

➢ Хууль тогтоомжид харшилсан үзүүлэлт, шаардлыг стандартад тусгахгүй байх.

1.3.Стандартчиллын үндсэн үүргүүд:

➢ Үр ашигтай ашиглах өндөр үзүүлэлт бүхий чанартай бүтээгдэхүүн бүтээхэд зориулан түүхий эд, материал, бүтээгдэхүүний шинж чанар, иж бүрдлийг үндэслэн бүтээгдэхүүний чанарын шаардлагыг тогтоох;

➢ Бүтээгдэхүүний ашиглалтын нөхцөл, зориулалтаас хамаарч найдвартай байдлын түвшин болон туршилт, шалгах арга, хэрэгслийг багтаасан чанарын

үзүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх;

➢ Бүтээгдэхүүний чанарыг хангах зорилгоор загвар, хэлбэр, хэмжээний тохиромжгүй байдлыг арилгах, үйлдвэрлэл зохион бүтээлтийн хүрээнд тавигдах хэм хэмжээ шаардлагыг тогтоох;

➢ Бүтээгдэхүүний ашиглалтын үр ашигтай байдал, харилцан оруулалтын түвшинг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг механикжуулах, автоматжуулах, үйлдвэрийн бүтээгдэхүүнийг ижилтгэн хөгжүүлэх;

➢ Улсын хэмжлийн нэгжийн эталон физик хэмжигдэхүүн болон хэмжих арга, хэмжих хэрэгслийн хэмжлийн нарийвчлалыг боловсронгуй болгон хэмжлийн нэгдмэл байдлыг хангах;

➢ Үйлдвэрлэл, техник хэрэгсэл, хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, стандарт боловсруулах, мэдээлэх, үйл ажиллагааг хөгжүүлэх, ангилал, кодлох, техник, эдийн засгийн мэдээлэл өгөх, автомат удирдлагын систем ашиглах, бүтээгдэхүүнийг ижилтгэх, баримт бичгийн систем тогтоох;

➢ Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт шинжлэх ухаан техникийг өргөн хэрэглэхтэй холбогдуулан нэгдсэн нэр томьёо, тэмдэг, тэмдэглэгээг тогтоох;

➢ Хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартын тогтолцоог бүрдүүлэх;

➢ Байгалийн баялгийг үр ашигтай хэрэглэх, ашиглалтыг сайжруулах стандартчлалыг тогтоох;

➢ Хүрээлэн байгаа байгаль орчныг хамгаалах стандартын тогтолцоог бий болгох;

➢ Шинжлэх ухаан, техникийн хөгжилтэй уялдуулан гадаад худалдааг боловсронгуй болгох нөхцөлийг бүрдүүлэх;

➢ Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор ажил, үйлчилгээний стандартыг боловсронгуй болгох.

(Үргэлжлэл нь дараагийн дугаарт)
Бэлтгэл хурандаа Ц. ДОРЖХҮҮ

ӨНӨӨГИЙН МОНГОЛЫН НИЙГМИЙН ОЮУН САНААНЫ АЙ САВЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, АГУУЛГА, ЧИГ ХАНДЛАГА

“Нийгмийн оюун санааны ай сав” гэж юу яриад байна вэ гэж асуух хүн захаас аван тохиолдоно. Тухайн нийгэм оршин тогтнож, хөгжиж амьдрах нэг төрлийн орчин, амьдрах тодорхой аргуудаар дамжиж, улс хоорондын өнөөгийн даяаршиж байгаа ертөнцөд хувь бие хүн өөрийн байр сууриа олох үзэл, баримжаа, чиг зорилгыг тодорхойлж байдаг шинжлэх ухааны онол, үзэл баримтлал, ёс суртахууны байр суурь, үндэсний уламжлалт зан үйлдлийн хэм хэмжээ, үнэлэмж, үзэл, итгэл, дадал зуршил, шүтлэг бишрэл, үлгэр домгоос эхлэлтэй уран сайхны сэтгэлгээ, гоо сайхны мэдрэмж, таашаал зэргийг энэхүү ай сав өөртөө багтаадаг. Нэг талаараа хүний оршихуйн асуудлыг чиглүүлж, тодорхой үзэл бодолтой болгож байдаг нээлттэй тогтолцоо гэж энгийнээр тодотгож болох юм.

НИЙГМИЙН ОЮУН САНААНЫ АЙ САВЫН БҮРДЛИЙГ ТҮҮХЧЛЭН АВЧ ҮЗЭЖ БОЛОХ УУ?

Монголын нийгмийн оюун санааны орон зайд эрт үедээ амьдрах аргын тухай ардын билиг сургаал, бөө мөргөл гол цөмийг нь бүрдүүлж байжээ. Тэнгэрт нэг нар, газарт нэг хаан байх учиртай гэж үзэн хүчирхэг Монгол Улсаа үүсгэн байгуулсан Чингис хааны байлдан дагуулалтаар дэлхийн талыг эзэлсэн монгол цэргийн байлдах үр чадвар, төрийн тусгаар тогтнол, монгол эр хүний эр зориг, тэсвэр хатуужил, эзэнт төрдөө амь биеэ өргөн үнэнчээр зүтгэж ялалт байгуулдаг эрхэм чанар монголчуудын оюун санааны ай савд томоохон байр эзэлж байсныг бид эх түүхээсээ сайн мэднэ. ХҮҮ-ХҮЙ зуунаас эхлэн шарын шашин хүчтэй дэлгэрч “Ганжуур”, “Данжуур”-ыг бүрэн эхээр нь орчуулж номлох болсноор Буддын шашин, философийн үзэл монгол хүний ертөнц үзэхүйнх нь гол цөмийг нь бүрдүүлэх болжээ.

ХХ зууны эхэн үеэс улс үндэстнийхээ тусгаар тогтнолын асуудлыг хөндсөн үзэл санаа хүчтэй дэлгэрч, түгэн тархаж улмаар марксист үзэл санааг Оросоор дамжуулан оруулж ирсэн байдаг. Марксист үзэл Монголын нийгмийн оюун санааны ай савд түгэн тархахдаа ялсан пролетари орны ах дүүгийн тусламжтайгаар ядуу буурай орнуудад капитализмыг алгассан эв хамтын нийгэм цогцлоон бүтээх загвар бүтээх үзэл санааг үндэс болгож байлаа. Ийм агуулга бүхий үзэл санаа ноёрхсон хугацаа 70 орчим жил үргэлжилсэн юм. Энэ үеийн Монголын нийгмийн оюун санааны ай сав хэт үзэл сурталжсан, явууу хүрээнд эргэлдэж байсан онцлогтой. Ингэж үзэл сурталжсан оюун санааны ай савд үндэснийхээ түүх, уламжлалыг гуйвуулан бүдгэрүүлж, заримыг нь мартаж, бөө мөргөл, буддын шашны үзэл санаа, ёс дэгийг оюун санааныхаа ай саваас бараг шатан гаргаад байжээ. Дэлхийн хараа, сонорыг булаасан хүчтэй эзэнт гүрэн улсаа байгуулаад байсан үндэснийхээ бахархлыг ч бараг мартаад байв.

1990-ээд оноос либерал үзэл санаа Монголын нийгмийн оюун санааны ай сав руу орж ирлээ. Хувь хүний эрх, эрх чөлөөг тунхагладаг либерал үзэл санааны үндэстэй ардчилал, чөлөөт зах зээлийн тогтолцоо руу Монгол улс өнөө шилжилт хийж байна. Энэхүү шилжилт, өөрчлөлтийнхөө алдаа, оноог өнөө цагийнхан олон талаас нь тунгаан бодож эргэцүүлдэг, ил тодоор ярьж, бичдэг боллоо.

Нийгмийн энэ өөрчлөлт, шилжилтээр Монголын нийгмийн оюун санааны ай сав бүтцийн олон бүрдэл хэсгүүдтэй болж, агуулга нь ч эрс шинэчлэгдэж, чиг хандлага нь ч өөрчлөгдөж байна.

Өнөөгийн Монголын нийгмийн оюун санааны ай савын бүтэц, агуулгын хувирал монголчуудын уламжлалт ардын билиг сургаал, зүйр цэцэн үгс, ерөөл, магтаал, үлгэр, домог, оньсого, таавар, ардын дуу зэрэг нь уламжлалт мал аж ахуй эрхэлдэг амьдрах арга, монгол ахуйн гүнд үүсэн бий болж, олон зуун жил дамжин монголчуудын оюуны ай савд баяхилж, амьдралын чиг баримжаа, үзэл сургаал болж байсан түүхтэй. Улс орон хотжиж, хүн амын зонхилох хэсэг нь хот, суурин газар амьдрах болж байгаа нийгмийн бодит байдлаас улбаалж ялангуяа хүүхэд, залуучуудын оюун санааны ай саваас монгол ардын билиг сургаал шахагдах хандлага улам бүр илэрч байна. Өөрөөр хэлбэл баруунаас гаралтай сэтгэл хөөрөл дээр амилдаг зугаа цэнгэл, адал явдал, этгээд гаж явдал, үйлийг түүвэрлэх үзүүлдэг нийтийн урлагийн өнгөг үзэл санаа, этгээд чамин үг эхлэлг, дүр дүрслэлтэй мөргөлдөж ардын билиг сургаал маань зарим тохиолдолд буулт хийж орон зайгаа тавьж өгөх боллоо.

БӨӨ МӨРГӨЛ МААНЬ МУХАР СУСЭГ РҮҮГЭЭ ЯВЧИХААД БАЙНА УУ?

Зарим монгол хүний оюун санааны мухарт үлдцийн маягаар хадгалагдаж байсан бөө мөргөлийн ёс дэг, үзэл санаа өнөөгийн монголчуудын оюун санааны ай савд асар хурдтай түгэж, зарим хэсгийнх нь амьдрал, ертөнцийг үзэхүйн чиг баримтлал болох хандлага ажиглагдана. Төрийн тахилгын ёс заншлаа сэргээж, олон түмэн энэ үйлдлийг уухайлалн дэмжиж, нутаг усныхаа уул, хангайн тахилгад үй олноороо очиж ёслол үйлддэг болсон. Гэтэл энэхүү тахилгын байгаль дэлхийгээ хайрлаж хамгаалах, шүтэн бишрэх үзэл санаа нь гуйвж, харин ч олон машин, хүний хөлөөр газар нутгаа талхалж, хоол хүнсний болон бусад хаягдлаараа орчных нь газар нутаг, уул, усыг бузарлаж, бохирдуулдаг болсон баримтууд олонтоо илэрч байна. Бороо оруулж ган тайлах, байгаль дэлхийгээ баярлуулах гэх мэт шалтгаанаар нутгийнхаа уул, овоог тахиж тайдаг дэг ёс орон нутагт дэлгэрээд байна. Хот, хөдөөгүй бөөгийн чуулган, цугларалт хийдэг, түүгээр ч үл барам бөөгийн сургалт гэгчийг явуулж сертификат олгодог болжээ. Монгол Улсын хэмжээгээр 28.000 бөө бүртгүүлсэн тооцоо ч байдаг.

ДАХИН ДЭЛГЭРСЭН ШАШИН Ч ЮУ БОЛОХ ГЭЭД БАЙНА ВЭ?

1990-ээд оноос хойш буддын ба христийн шашны үзэл санаа, ёс, ёслол их эрчтэй дэлгэрч, нийгмийн оюун санааны орон зайд томоохон байр эзлэх боллоо. Буддын философи, шашны үйлийн үр, нүгэл, буян, дөрвөн үнэний тухай үзэл ойлголт олон түмний оюун санааны ай савд сууж чадаагүй байгаагаас хүмүүсийн зарим хэсгийн дотор хулгай, дээрэм хийх зэргээр нүгэлт үйл үйлдэхийг амьдрахын тулд хийж буй ердийн хэрэг гэсэн үзэл санаа газар авчээ. 1990-ээд оноос хотын дахин сэргэж, буяны үйл ажиллагаа явуулж буй манай ихэнх сүм, хийдүүд буддын шашны зан үйл хийлгэхэд голчлон анхаараад шүтлэгтэн олон түмэнд төлбөртэй үйлчилгээ үзүүлдэг болсноор манай сүм хийдүүд бизнесийн байгууллага болж хувиран буддын шашны зан үйл, ёс дэг дэлгэрч олон түмэн мухар сүсгийн замаар орох боллоо. Одоогийн байдлаар улсын хэмжээгээр 300 орчим буддын шашны сүм, хийд үйл ажиллагаа явуулдаг юм байна. Зөвхөн нийслэл хотод 200 шахам буддын сүм, хийд байна. Энэ олон сүм, хийд шүтлэгтэн олон түмнээ соён гэгээрүүлэх ажил хийгээд байна уу эсвэл шашны зан үйлээр дамжуулан мунхруулаад байна уу гэсэн асуулт тавигдаж байгаа юм. Амьтны амь битгий хөнөө, худал бүү хэл, эс өгснийг бүү ав гэх мэт буддын шашинтан хүний ёс суртахууны хамгийн энгийн дүрэм ч нийгмийн амьдралд огт хэрэгжихгүй байгаагаас үзвэл Монголын нийгмийн оюун санааны ай савд тархаад байгаа буддын шашны үзэл санаа, философи нийгмийн сэтгэл зүйд нутагшихгүй байгаа юм байна гэсэн дүгнэлт хийж болох баримт юм. Харин сүүлийн үед буддын шашны агуулга, үзэл санааг философи талаас нь олон түмэнд тайлбарлах зарим оролдлого хийгдэх болсон эерэг тал ажиглагдах болов.

ЕРТӨНЦИЙН ЭЗНИЙГ ХАЙРЛАДАГ ШИГЭЭР МОНГОЛ ХҮН БИЕ БИЕЭ ХАЙРЛАХ ИТГЭЛ ҮНЭМШИЛТЭЙ БОЛСОН УУ?

1990-ээд оноос эхлэн нийгмийн ядуу зүдүү амьдралтай давхаргад хоол хүнсний туслалцаа үзүүлэх, хүүхэд, залуучуудад

англи хэл зааж сургах халхавчаар христийн шашны үзэл номлолыг түгээж эхэлсэн юм. Одоогоор зөвхөн улсын хэмжээгээр христийн шашны 440 орчим сүм, хийд, чуулган үйл ажиллагаа явуулж байгаагаас зөвхөн нийслэл хотод 170 орчим христийн сүм, хийд үйл ажиллагаа явуулдаг гэсэн мэдээ байна. Өнөөдөр Монголын гурван эмгэгтэй тутмын нэг нь хүчирхийлэлд өртөж, нэг жилд 4200 орчим айл өрх гэрлэлтээ цуцлуулж байгаа баримт бүртгэгдэж байгаа юм. Гэр бүлээ цуцлуулагчдын бараг 80 орчим хувь нь 7-10 жил хамт амьдарсан гэр бүл байна. Нэг айл өрх дунджаар 2-3 хүүхэдтэй гэж бодвол хэчнээн хүүхэд төрсөн эцэг эсвэл эхээсээ амьдаараа өнчирч, амьдралын түшиг тулгуургүй амьдрах болж байгаа нь харагдана. Гэр бүлийнхээ “сул хүйсийн” гишүүнийг хүчирхийлж, гэрлэлтээ цуцлуулж, төрүүлсэн хүүхдээ өнчрүүлж байгаа эцэг, эх хөндлөнгийн хэн нэгнийг хайрлаж энэрэх үү гэсэн асуулт гарна. Христийн шашны хүн хүнээ энэрч хайрлах үзэл номлол нийгмийн оюун санааны ай савд хүн ардад ач тусаа өгөхөөр байр эзэлж чадаж байна уу гэсэн асуулт ч эндээс тавигдах нь.

МАРКСИСТ ҮЗЛЭЭ ХАЛСАН НЬ

Марксист үзэл сургаалыг шүүмжлэн социалист тогтолцоог нураах зорилготой орж ирсэн либерал үзэл суртал Монголын нийгмийн оюун санааны ай савд өөрийнхөө байр суурийг эзлэх үйл явц эхлэн үргэлжилж байна. Энэ үзэл номлолыг монголчууд бэлэн загвараар нь хүлээж авах гэж оролдлоо. Эх орондоо социалист тогтолцоог бүрдүүлэхээр 70 жил зорьж тэмцээд бүтээлгүй болсон, буддын шашин, бөө мөргөлийн үзэл санааны үлдэгдлийг оюун санаандаа нууцлан тээж явсан, дорнын соёлтой монголчуудын ахуй амьдралын хэв маяг, нийгмийнх нь хөгжлийн түвшин, социалист сэтгэлгээнийх нь итгэл үнэмшил, үнэлэмжтэй чөлөөт зах зээл, ардчилсан тогтолцооны онол, суртахууны үндэс болдог либерал үзэл баримтлал зарим талаар нийцэхгүй байгаа бодит байдлаас дүгнэлт хийж, өөрийнхөө улс, үндэстний онцлогт зохицуулан либерал үзэл онолыг дахин боловсруулах учиртай байжээ. Либерал үзэл баримтлалын хувь хүний эрх чөлөөний тухай үзэл санаа ямар ч хамаагүй аргаар өмч хөрөнгөтэй болох, юу хүссэнээ ярьж, үйлдэж байх, бусдыгаа болон нийгмээ үл бодох, амиа бодох үзлийн хамгийн туйлгарсан агуулгаар монгол хүний оюун санааны ай сав руу орж иржээ. Гэр бүлээс эхлээд ямар нэг хамтлаг, нийтлэг, цаашлаад нийгэмд амьдарч байгаа хэн боловч туйлширсан амиа хичээсэн үзэл итгэлтэй болчихоор үл нийгмийн баялаг арвижихаа больж, өмч хөрөнгө завшигчид олширч, эх болсон газар шороо, байгалиа сүйтгэж, эдийн засгийн дахин хуваарилалт шударга бусаар хийгдэж, баян, ядуугийн эрс ялгаа гардаг юм байна гэдгийг Монголын нийгмийн өнгөрсөн 30 орчим жилийн үйл явц батлан харууллаа.

МОНГОЛУУД БИД ГЭНЭН БАЙЖЭЭ

Ардчилал, зах зээлд шилжингүүт л улс орон элдэв саад тотгоргүй эрчимтэй хөгжөөд эхлэх юм шиг, ямар ч аргаар хамаагүй өмч хөрөнгөтэй болж болох юм шиг, хувь хүний эрх чөлөө гэдэг ямар ч хариуцлага хүлээхгүйгээр дүр зоргоороо авирлаж болох, үүрэг үгүй эрх юм шиг санаж ойлгож байсан олонх өнөөдөр ардчилал, зах зээлийн нийгмийн олон эрсдэл, шалгууртай учирлаа. Монголын нийгмийн өнгөрсөн 30 жил учир замбараагүй хөдөлгөөний он жилүүд болж түүхэнд үлдэж байна. Эрх чөлөөт хүний хийсэн сонголт, үйлдсэн хэргийнхээ төлөө хариуцлага хүлээдэг ардчилсан нийгмийн ёс суртахууны түгээмэл хууль манай Монголд үйлчлэхгүй байна. Хариуцлагагүй үйлдэл хийх энэхүү үлгэр жишээ нийгмийн оюун санааны ай савд тархаж, улмаар хийсэн сонголтынхоо төлөө монгол хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, ёс суртахууны ямар ч хариуцлага хүлээхгүйгээр амьдарч болдог юм байна, түүгээр ч үл барам эд материалын хувьд элбэг хангалуун амьдарч болдог юм байна гэсэн үзэл, итгэл бат суучихсан байна. Ингээд нийгмийн хэмжээгээр улс төр, эдийн засаг, эрх зүйн хүрээнд хариуцлага хүлээхгүй өөрийнхөө хүссэнээр амьдрах эрмэлзэл, итгэл үнэмшил төлөвшиж, ёс суртахуун, эрх зүйн хориг үйлчлэхээ больжээ гэж дүгнэж болохоор баримтууд алхам бүрт дайралдах боллоо.

ШИНЖЛЭХ УХААНЫ МЭДЛЭГИЙГ Л ЭРХЭМЛЭЭ

Өнөөгийн Монголын нийгэм, бие хүний оюун санааны орон зайд шинжлэх ухааны мэдлэг, үзэл итгэл томоохон байр эзэлдэг болсон. Одоогийн байдлаар гурван хүн тутмын нэг нь ямар нэг шатны сургуульд суралцаж, шинжлэх ухааны боловсрол эзэмшиж байна. Хүүхэд, багачууд ерөнхий боловсролын сургуулийн бага ангиас эхлээд л 12 дугаар анги төгстөлөө бүх төрлийн шинжлэх ухааны суурь боловсролыг эзэмшидэг. Их, дээд сургуульд аль нэг шинжлэх ухаанаар мэргэшин суралцдаг. Монголын нийт хүн амын зонхилох хувь нь ямар нэг хэмжээний шинжлэх ухааны боловсролтой болсон, болж байгаа гэж үзэх бүрэн үндэс байна. Харин өнөөдөр ийм тоон үзүүлэлт байгаа атлаа яагаад шашин, бөө мөргөл, зурхай руу хошуурч нэг хэсэг нь мунхарч төөрөлдөөд байдаг юм бол доо гэсэн асуулт тавигдадаг. Хүн амын оюун санааны ай савд том байр эзэлж буй, системтэйгээр олгож байгаа шинжлэх ухааны боловсролын чанарын тухай ярих хэрэгтэй юу, эсвэл заавал бөө, шашны шүтлэг бишрэл, үзэл итгэл рүү яваад байдаг нь хүн, түүний дотроос монгол хүний төрөлх мөн чанартай холбоотой юу эсвэл энэ хоёр асуудал зэрэгцэн тавигдах учиртай юу гэсэн асуудал хөндөгдөх нь.

СОНГОГУУДЫГ Л УНШВАЛ ...

Урлаг, уран зохиол, гоо сайхны мэдрэмж, таашаал, үзэл, үнэлэмж нийгмийн оюун санааны ай савд тодорхой байр сууриа эзэлж байгаа боловч олонх нь гоо сайхны хууль, эерэг үнэлэмжийг амьдрал ахуйгаа зохион байгуулах чиг баримжаа болгож чадаж байна уу гэсэн асуудал өнөөдөр хурцаар тавигдаж байна. Улс үндэстэн болгоны анхаарал татдаг, тэдний амьдрахуйн амин чухал асуудлыг ямар ч цаг үед хөндөж бодол, эргэцүүлэл, ухаарал өдөөж байдаг дэлхийн сонгодог урлаг, уран зохиолын тэргүүлэх бүтээлүүдтэй монгол хүн ямар нэгэн үзэл сурталд хавчигдалгүйгээр танилцдаг, үнэлж цэнгэдэг, аль нэг уран бүтээлийн бүтээсэн дүр, дэвшүүлж үнэлсэн үзэл санаа, агуулгын талаар эргэцүүлэн бодож өөрийнхөө үнэлгээ өгдөг болж байна. Өнөөгийн дэлхий дахинд уншигдаж байгаа өрнө, дорнын уран зохиолын эрт, эдүгээгийн шилдэг бүтээлүүдийн зарим хэсгээс уншдаг, дэлхийн уран барилга, уран зургийн түүхэнд тодорсон бүтээлүүдтэй интернэтээр танилцдаг, үзэж таашаадаг болсон байна.

Ийм эерэг тал, сайн хандлага байгаагийн зэрэгцээгээр сав сөрөг хандлага, дүр сонирхол байнга илэрч байна. Хүн амын олонх хэсэг ялангуяа хүүхэд, залуучуудын оюун санааны ай савд нийтийн урлагийн адал явдал, гэмт хэрэг, сүнс, хулгай дээрэм, аллага хядлага, сексийн үйлдлийг харуулсан кино зэргийн бүтээлүүдийн агуулга, үйл явдал, дүр дүрслэл томоохон байр эзэлдэг боллоо. Нийтийн урлагийн ийм бүтээлүүд манай хүүхэд, залуучуудыг зорилго, чиглэлтэйгээр боловсрол эзэмших, ирээдүйгээ бодож төлөвлөх, эрүүл мэндээ сахиж хамгаалах, ахмад үе, багш нараа хүндэтгэж, тэднээс суралцах, шинжлэх ухааны онолын мэдлэг эзэмших, уран зохиолын шилдэг сайн ном олж уншиж, бодож эргэцүүлэх улмаар оюун ухаанаа хөгжүүлэх зэрэг олон тулгарсан зорилт, асуудлуудаас нь тэднийг холдуулж, аль болохоор хөөр шүүгиантэй, зугаа цэнгэлтэйгээр чөлөөт цагаа өнгөрөөдөг дадал зуршил, сэтгэлгээний хэв загвартай болгож байж болзошгүй юм.

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН ОЮУН САНААНЫ АЙ САВЫГ ОНЦЛОБОЛ ...

Ардчиллагдн хөгжиж байгаа Монголын нийгмийн хамгийн

идэвхтэй иргэдийн нэгэн хэсэг болсон цэргийн алба хаагчид оюун санааны хувьд өөрийн онцлогтой. Төр, засгаас батлан гаргаж байгаа хууль, тогтоомжуудыг ямар нэг тайлбаргүйгээр, бэрхшээл, зовлонгоо дурдалгүй биелүүлдэг сайхан уламжлал, өнөөгийн сахилгажсан эрүүл ухаанаараа манай цэргийн албаныхан монгол түмнийхээ өмнө нүүр бардам байх эрхтэй. Байлдааны зэвсэг, техникийн шинэчлэлийн онол, практикийн үндсийг байнга судалж, байлдах урлаг, уран чадвараа төгөлдөржүүлэх үүргээ тасралтгүй гүйцэтгэж байдгийг өнөөгийн манай цэргийн алба хаагчдын сорилт, шалгалтын үзүүлэлтүүд, олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаа, оролцсон цэргийн алба хаагчдын үүргийн биелэлт нотлон харуулдаг. ЗХЖШ-ын удирдлагаар монгол цэргүүд төмөр замаа бие даан барьж чаддагийг нотоллоо. Энэ бол манай цэргийн алба хаагчдын нэг ёсны нээлт болж байна шүү дээ. Өнгөрсөн 30-аад жилийн хугацаанд хааж байгаа албандаа үнэнч, төрийн хууль, цэргийн дүрмүүдийнхээ зүйл, заалтыг хэлбэрэлтгүй сахиж, хичээл зүтгэлтэй хөдөлмөрлөсөн цөөн салбаруудын нэгэнд манай Зэвсэгт хүчний албан хаагчид тоологдоно. Манай цэргийнхэнд цаг баримталдаг нэг бахархмаар давуу тал байдгийг олон түмэн мэддэг. “Чи ухамсартай цэргийн хүн” гэсэн ард түмнээс олгосон өргөмжлөлөө одоо ч манай цэргийнхэн алдаагүй яваа. Ухамсартай хүн гэдэг нь одоогийн үзэл, ойлголтоор бол бие дааж шийдвэрээ гаргадаг, үйлдлийнхээ хариуцлагыг бултаж займчилгүй хүлээж чаддаг иргэн гэсэн ухагдахуун болж л дээ.

ЦООХОР МЭДЭЭЛЭХД ХААЛТТАЙ СИСТЕМ БАЙВАЛ ...

Улсын хэмжээгээр 2018 оны байдлаар өдөр тутмын 10, 3-4 хоног тутмын хоёр, долоо хоног тутмын 23, 10-14 хоногийн 37, сар тутмын 13, нийт 92 төрлийн сонин хэвлэгдэж өдөр тутмын 10 сонин 9 935 452 хувиар борлогдсон байна. Нийт сонин борлуулалтын тоо 14 саяд хүрчээ. 72 төрлийн сэтгүүл хэвлэгдэж 1 сая гаруй дугаарын борлуулалт хийсэн байна. Өргөн нэвтрүүлгийн болон Улаанбаатар, орон нутагт нэвтрүүлгээ цацдаг 128 телевиз ажиллаж, хувийн байгууллага ба хувь хүний эзэмшилд байдаг 109 мэдээллийн сайтууд үйл ажиллагаагаа явуулж байна. Сэтгүүлүүдийг “Шинжлэх ухаан, амьдрал”, “Шинжлэх ухааны мэдээ”, “Эрчим хүч”, “Боловсрол судлал”, “Эм зүй”, “Хууль дэглдэх ёс” зэрэг нэршил талаас нь таамаглаж үзвэл 15 орчим сэтгүүлд шинжлэх ухааны мэдлэг, мэдээлэл бичигддэг юм байна гэсэн тооцоо хийж болохоор байгаа юм. Манай өдөр тутмын 10 сонины аль ч дугаарт шинжлэх ухааны мэдлэг, мэдээллийн агуулгатай нийтлэл нэн ховор байдаг. Хамгийн их борлуулалттай “Өдрийн сонин”-ы 2019 оны 10, 11 дүгээр сарын дугааруудыг шүүж үзэхэд шинжлэх ухааны агуулга бүхий нэг л нийтлэл бичигдсэн байна. Эндээс өнөөгийн Монголын нийгмийн оюун санааны ай савыг мэдээллээр дүүргэж байгаа төрөл бүрийн нийтлэл, нөвтрүүлгийн бүрдэлд шинжлэх ухааны мэдлэг, мэдээллийн орон зай, агуулга илт үгүйлэгдэж байгааг үзэж болохоор байгаа юм. Манай хэвлэл мэдээллийн томоохон орон зайг бараа, үйлчилгээ, шоу үзвэрийн зар сурталчилгаа эзэлж байгаагийн тусгал болсон энэ чиглэлийн мэдээлэл олон түмний оюун санааны ай савд их том эзлэхүүнтэй болжээ. Ийм төрлийн мэдээлэл нь өөрийнхөө агуулга, хараа булааж, анхаарал татам байдлаараа олон түмнийг ялангуяа хүүхэд, залуучуудыг илбэдэн төөрөлдүүлж сурч боловсрох ажлаас нь хөндийрүүлж, бүхэлд нь авч үзвэл нийгмийн оюун санааны орон зайг саармагжуулж байна. Шашны ёс, ёслол үйлдэх, мэргэ төлөг тавих, зүүд тайлах гэх мэт агуулгатай зар сурталчилгаа ч олонтоо цацагдаж мэдээлэгдэх болсон. Цахим хэрэгслээр цацаж буй мэдээллүүд Монголын нийгэмд гутранги үзэл үндэслэж, цэцэглэх олон талын өдөөц болж байна.

ОЮУНЫ САНААНЫ АЙ САВ ЭКОЛОГИЖНА

Сүүлийн үед хүн, байгаль орчны хоорондын харилцаанаас үүсэж байгаа зөрчил, байгалийн нөөц хомсдож, агаар, орчин бохирдож, экологийн тэнцвэрт харилцаа, байгалийн унаган төрх алдагдаж, дэлхийн дулаарал өсөж байгаа олон шалтгааны улмаас хүн төрөлхтнийг хамраад байгаа нийтлэг асуудлын шийдлийг эрж хайсан үзэл санаа өдөөгдөн сэргэж, нийгмийн оюун санааны ай сав руу хүн амын экологийн боловсрол, экологийн эрх зүй, экологийн ёс суртахуун зэрэг олон шинэ үзэл, ойлголт түрэн орж ирээд байна. Үүнийг нийгмийн оюун санааны орон зай экологижиж байна ч гэж үзэж болох юм.

ОЮУН САНААНЫ ОЮУНЖИЛТ

Өнөөгийн Монголын нийгмийн оюун санааны ай савын бүрдэл хэсгүүдийнхээ найрал зохицол, чиглэмж, үнэ цэнтэй агуулга, хандлагаараа нийгмийн хүлээлтийг хэрэгжүүлж чадахгүй байгаагийн гол шалтгаан нь түүний оюунжилтын түвшин доогуур байгаатай холбоотой. Иймд нийгмийн оюун санааны ай савын бүрдлийн агуулга, бүтцийг түүний оюунжилт талаас авч үзэн судлах хэрэгтэй. Нийгэм, хувь хүний оюунжилт нийгмийг нэгтгэгч эхлэл болдог институцт болдог онцлогтой. Амьдарч байгаа эрин цаг, нийгмийнхээ үнэнийг танин мэдэж ухаарсан мэдлэг нийгмийн оюунжилтын цөм байх болно. Эцсийн эцэст тухайн ард түмнийг үнэн л нэгтгэж, тодорхой зорилго, чиглэлтэй, мөрөөдөлтэй болгож чадна. Өнөөдөр манайд ийм оюунжилтын цөм болсон үнэн танин мэдэгдэж бүрэлдэн тогтож чадаагүй байгаа юм. Ийм үнэнийг тээсэн оюунжилтын агуулгад үе уламжлан ирж, шинэ агуулгаар баяжсаар байдаг ёс суртахууны үнэт баримжаалал, Монголын төр, түүний тусгаар тогтнолын түүхэнд монгол цэргийн байгуулсан гавьяа, буддын шашны философи үнэн (Буддын философийн хоосон чанар, шүтэн барилдахуй, өөрөөсөө эс бүтэхүй, үйлийн үр, дөрвөн үнэн, нүгэл, буян зэрэг үзэл, ойлголтууд юуны өмнө хэлж байна), Монголын болон дэлхийн сонгодог урлаг, уран зохиолын дүр, дэвшүүлж тавьдаг философи үзэл санааны мэдрэмж, таашаал, үнэлэмж, шинжлэх ухааны тал бүрийн батлагдсан мэдлэг, монгол үндэстний амьдрах аргаар батлагдсан эрүүл ухааны мэдлэг, ардын билиг сургаал, нийгмийн туршлага, хүний амьдралын учир утгаа ухаарч байгаа философи эргэцүүлэл зэрэг бүрдлүүд багтана гэж үзэж байна. Нийгмийн оюун санааны ай савын оюунжилтын түвшин доогуур байвал цахим хэрэгслээр түгэж байгаа яриа, ам дамжсан хов, цуурхал, бөө мөргөл, шашны мунхруулга, зөн совин, өдөр тутмын цоохор мэдээ зэрэгт итгэж нийтийн урлагийн дүр дүрслэл, шог хошин үзүүлбэрүүдийн марзганалыг дагаж хошуурсаар нийгэм бүхэлдээ хөгжил дэвшлийнхээ чиг баримжааг алдаж, хувь хүн үзэл санааныхаа хувьд саармагжиж, нийгэмд эзлэх байр сууриа олохоо байж, амьдралын учир утгаа ухаарч, ойлгож чадахаа байж ч болох юм гэж үзэж байна. Францын философици Мишель Фука “Оюунжилт бол амьдралын үйл ажиллагааны эрэл, өөрийгөө өөрчлөх туршлага, амьдралын үнэнд хүрэх гэсэн эрмэлзэл тэмүүлэл юм” гэсэн санаа илэрхийлсэн байна. Өнөө үед Монголын нийгмийн оюун санааны орон зайн оюунжилт эцэстээ хувь-бие хүн, нийгмийн бүлэг, нийтлэгүүд, цаашлаад бүхэл нийгмээрээ хүлээн авч байгаа олон талт мэдээллүүддээ задлан шинжилгээ хийж, нэгтгэн дүгнэж, шинжлэх ухааны үндэслэлтэй, амьдралын үнэнийг олж тогтоох чадвараас л шалтгаана гэж үзэж байна. Хүн бүр ямар нэг хэмжээгээр оюунлаг чадвартай байдгийн зэрэгцээ оюунжилт хувь хүнийг илүү нээлттэй, өөрийнх нь оролцооны хэр хэмжээгээр байнга хувирч, өөрчлөгдөж байдаг үйл явц юм. Нийгэм, хувь хүн өөрийнхөө бүтээлч эрлийн хэмжээгээр оюуныхаа ай савыг тэлж, сэтгэлгээгээрээ илүү өргөн хүрээний орон зайг эзэлж байх бололцоотой.

Монгол Улсын гавьяат багш, доктор, профессор Б.ГАЛИНДЭВ

Дугаарын зочин

Энэ удаагийн “Зочин”-ы хойморт Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор, профессор, дэд хурандаа Б.ЭРДЭНЭЧИМЭГИЙГ онцлон уриллаа. Тэр бээр Батлан хамгаалах салбарын 2019 оны Тэргүүний эрдэм шинжилгээний ажилтнаар шалгарсан манлайлагч эрдэмтний нэг юм.

Сонины уншигчдад өөрийгөө танилцуулахаас ярилцлагаа эхлэх үү?

-Тэгье. Би бээр Өмнөговь аймгийн Булган сумын нутагт төрсөн. 1993 онд Өмнөговь аймгийн нэгдүгээр арван жилийн дунд сургууль, 1997 онд Улаанбаатар хотод Гадаад хэлний дээд сургууль /одоогийн Хүмүүнлэгийн ухааны их сургууль/, 2001 онд Удирдлагын академийг тус тус төгссөн. Нөхөр, гурван хүүхдийн хамт амьдардаг. Нөхөр маань Баянхонгор нутгийн уугуул, барилгын инженер мэргэжилтэй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг. Гурван хүүхэд маань ерөнхий боловсролын дунд сургуульд суралцаж байна.

Батлан хамгаалах салбартай холбогдсон түүхийг эргэн дурсвал ...

-Хувь зохиолоор холбогдсон гэх үү дээ. 1998 оны 2 дугаар сард Батлан хамгаалах яаманд мэргэжилтнээр томилогдлоо. Тухайн үед С.Баасанхүү генерал тус яамны Бодлого төлөвлөлтийн газар /одоогийн Стратегийн бодлого төлөвлөлтийн газар/-ын дарга байсан юм. “Чамас хэлний болоод хуулийн шалгалт авна” гээд надад “Батлан хамгаалах хууль тогтоомжийн эмхэтгэл I, II” ботийг өгөөд үүнийг сайн судал гэсэн. Тэгээд л уншиж, уншиж /барга цээжлээд л/ сарын дараа шалгалт өгөөд орсон доо. Аав маань бас цэргийн хүн байсан нь Батлан хамгаалах салбартай холбогдоход нөлөөлсөн байх. Тус яаманд зургаан жил ажиллах хугацаандаа чадварлаг хамт олон, сайн дарга нарын дэмжлэгтэйгээр албан бичгийн найруулга, боловсруулалт, цаг ашиглалт зэрэг их зүйлийг сурсан. Тиймээс С.Баасанхүү генерал, Д.Налжир хурандаа болон газрын хамт олондоо маш их баярлах явдгаа илэрхийлэв. Миний өдий зэрэгтэй яаа маань эдгээр эрхэм хүмүүстэй холбоотой.

Эрдмийн хамт олныхоо тухайд онцолбол ...

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнд 2005 онд эрдэм шинжилгээний ажилтнаар томилогдсон. Намайг томилогдох үед Батлан хамгаалах судлалын төвийн даргаар өмнө нь яаманд манай газрын орлогч даргаар ажиллаж байсан, доктор, дэд профессор, хурандаа Б.Отгон-Уул дарга маань ажиллаж байлаа. Ихэд баярласныг яана. Мөн яамны МХШҮГ-ын даргаар ажиллаж байсан хурандаа С.Ноов томилогдож ирэв. Намайг томилогдохоос өмнөхөн Батлан хамгаалахын сайдын зөвлөхөөр ажиллаж байсан Н.Жалбажав генерал манай төвд эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллаж байгаад БХИС-ийн захирал болсон байв. Ямар сайндаа л БХЯ-наас ирсэн шалгалтын багийнхан “Өө яамны хэд чинь энд ирээд тусдаа нэг төв байгуулчихсан юм биш үү” гэж наргиа болгож байх вэ дээ.

надад хичээлийн конспектоо бүгдийг нь өгөөд намайг дагалдуулан хичээл заадаг байв. Үнэхээр мундаг хүн байсан даа. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын чиглэлээр судалгаа хийх, судалгааны ажил удирдах, цаашид энэ чиглэлээр гүнзгийрэн хөгжихөд минь О.Үржин генералын маань заавар, зөвлөгөө, дэмжлэг их байдаг. Судалгааны ажил хийх үед гацаанд орох, бухимдах, материал олдохгүй байх зэрэг янз бүрийн асуудал үүснэ. Тэр бүхэнд “Чи чадна, чадах ёстой” хэмээн зоригжуулан урам нэмж, сэтгэл харамгүй зөвлөж байдаг шинжлэх ухааны доктор, профессор О.Үржин генералдаа ихэд талархдаг. Би ер нь их азтай хүн. Батлан хамгаалах салбарын түүхээ болсон шилдэг дарга нартай хамт ажиллаж байснаараа бахархдаг. Манай төвийн даргаар генералууд томилогдох нь түгээмэл. Шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал Б.Эрдэнэбат, О.Үржин, доктор, профессор, хошууч генерал З.Болдбаатар, доктор, дэд профессор, бригадын генерал Ч.Сосорбарам гээд. Мөн шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал Д.Мягмар, доктор, профессор, хошууч генерал Ч.Улаанхүү, хурандаа Т.Наранхүү, хурандаа Л.Болдбаатар нартай хамтран ажиллаж байсан. Манай төв бол туршлагатай ахмад үе, чадварлаг залуу үеийнхний төлөөллөөс бүрдсэн чадварлаг хамт олон. Бид Батлан хамгаалахын 2016, 2017, 2019 оны Тэргүүний судалгааны төвөөр шалгарч байлаа. Хариуцлагатай ажил хашиж байсан мундаг хүмүүстэй хамт нэг төвд ажиллаж байсандаа үргэлж баярлаж, бахархаж явдаг.

Өөрийнхөө судалгааны ажил, бүтээлийн талаар тодруулна уу?

-Судалгааны ажлын тухайд гэвэл нэг сэдэвт бүтээл хоёр, хамтран зохиогчоор нь оролцсон, хянан тохиолдуулсан болон эмхэтгэсэн ном 11 байна. Мөн улсын захиалгатай судалгааны ажил зургаа, салбарын захиалгатай 11 судалгааны ажилд гүйцэтгэгч, зохицуулагчаар, мөн гурван судалгааны ажилд удирдагчаар ажилласан. Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, стратегийн онолын үндэс, өөрийн болон хөрш орнуудын батлан хамгаалах бодлогод холбогдох асуудлыг судалж, судалгааны үр дүнгээр эрдэм шинжилгээний 20 илтгэл, 38 өгүүлэл бичиж нийтлүүлжээ.

Өнгөрөгч он таны хувьд амжилт, бүтээл, дурсамж дүүрэн байсан

Дэд хурандаа Б.Эрдэнэчимэг: БАХАРХАХ ЗҮЙЛ ОЛОН БИЙ



Дэд хурандаа Б.ЭРДЭНЭЧИМЭГ

-Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалаар мэргэшиж буй магистрант, докторантын судалгааны түшиц төв нь Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төв юм. Тиймээс бид энэ чиглэлд ихээхэн анхаарал хандуулдаг. Миний хувьд аюулгүй байдлын магистрантур, докторантурт суралцагсдад “Үндэсний аюулгүй байдал”, “Батлан хамгаалах бодлогын үндэс-I”, “Батлан хамгаалах бодлогын үндэс-II” зэрэг мэргэжлийн хичээлүүдийг нь зааж, тэдний судалгааны арга зүйг дээшлүүлэхэд дэм болохыг хичээж явна. Өнгөрсөн хугацаанд аюулгүй байдлын ухаанаар найман магистрын ажлыг удирдаж хамгаалуулсан ба хоёр докторантын эрдэм шинжилгээний ажлын удирдагчаар ажиллаж байна.

Батлан хамгаалах салбарын судалгааны байгууллагын гишүүнчлэлийн хувьд тодотговол ...

-Миний хувьд ҮБХИС-ийн дэргэдэх Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалаар магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга, Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын докторын хөтөлбөрийн хорооны гишүүн, ҮБХИС-ийн Аюулгүй байдлын профессорын багийн ахлагч, БХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн Аюулгүй байдал, батлан хамгаалахын дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг томилгоот үүргийг хүлээдэг.

Зүүн хойд Азийн аюулгүй байдлын чиглэлээр зохион байгуулдаг олон улсын хурлын тухайд онцолж хэлбэл уншигчдад сонирхолтой байх болов уу?

-Та ч энэ талаар мэдээлэл сайтай байна шүү. Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн 2013 оноос хойш Зүүн хойд Азийн аюулгүй байдлын тулгамдсан асуудлаар олон улсын эрдэм шинжилгээний хурлыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн. Монгол Улсын аюулгүй байдлыг хангах нь улс орны батлан хамгаалах эрх ашгаас үүдсэн бүх салбарын эрх ашиг, зохицуулалттай уялдаатай өргөн хүрээний асуудал байдаг тул бид 2013 онд “Зүүн хойд Азийн аюулгүй байдал”, 2014 онд “Зүүн хойд Азийн эрчим хүчний аюулгүй байдал”, 2015 онд “Зүүн хойд Азийн хүрээлэн буй орчны аюулгүй байдал”, 2016 онд “Зүүн хойд Азийн дэд бүтцийн хөгжил, стратегийн ач холбогдол”, 2017 онд “Зүүн хойд Азийн орнуудын эдийн засгийн аюулгүй байдал ба хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж”, 2018 онд “Мэдээллийн аюулгүй байдал: Онол практикийн тулгамдсан асуудал”, 2019 онд “Зүүн хойд Азийн аюулгүй байдал ба Солонгосын хойгийн асуудал” сэдвийн дор долоон жил дараалан амжилттай зохион байгуулсан. Харин энэ жилийн тухайд, “Зүүн хойд Азийн бүс нутгийн аюулгүй байдлын орчин: Итгэлцлийг бэхжүүлэх нь” сэдвийн хүрээнд зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна. Манай уламжлалт олон улсын эрдэм шинжилгээний хуралд дотоод, гадаадын хамтын ажиллагаатай байгууллагуудаас эрдэмтэн судлаачид идэвхтэй оролцдог.

Улс орныхоо хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг цөөн үгээр илэрхийлбэл ...

-Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн

52 дугаар захирамж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 65 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг “Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого /2020-2050/-ын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх “Дунд хугацааны төлөвлөгөө /2020-2025/-г боловсруулан, энэ оны 1 дүгээр сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Миний бие “Амар тайван, аюулгүй нийгэм” гэсэн дэд ажлын хэсэгт томилогдон ажилласан ба энэхүү дэд бүлэгт улс орны батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх, улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангаж, хил хамгаалалтын чадавхыг дээшлүүлэх, уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар ирэх 30 жилийн үйл ажиллагааны чиглэл ямар байвал зохистой вэ гэдэг дээр ажилласнаараа бахархаж явна.

Та эрдэмтэн судлаачийн хувьд Батлан хамгаалах үйл ажиллагааны талаарх ойлголтоо уншигчидтай хуваалцана уу?

-1990 оноос хойш уламжлалт бус аюултай холбоотойгоор батлан хамгаалах асуудал их өргөн агуулгаар тодорхойлогдох болсон. Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа бол үндэсний аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг юм. Тиймээс ч “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт “Батлан хамгаалах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мөн” гэж батлан хамгаалах үйл ажиллагааг өргөн утгаар нь тодорхойлсон.

Энэхүү тодорхойлолтоос харахад батлан хамгаалах үйл ажиллагаа нь улс, нийгмийн бүхий л хүрээг хамарч байгаа бөгөөд төрийн батлан хамгаалах бодлого нь нэгдмэл удирдлагатай, зохион байгуулалттай арга хэмжээгээр хэрэгжих нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, улс орны батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх нь бүх нийтийн үйл хэрэг байна гэсэн үг. Ер нь улс орны үндэсний аюулгүй байдлын системийн хувьд аливаа бодлого, эрх зүйн зохицуулалтыг боловсруулах арга зүй нь нэгдүгээрт, үндсэн суурь нь “Үндсэн хууль”-ийн заалтууд, хоёрдугаарт, Үндсэн хуулийн заалтуудын утга агуулгад тулгуурлан боловсруулагдсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, гуравдугаарт, Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын утга агуулгатай нийцүүлэн боловсруулагдсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”, дөрөвдүгээрт, Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалын утга агуулгатай нийцүүлэн боловсруулагдсан “Төрөөс батлан хамгаалах талаар баримтлах бодлого”, тавдугаарт, дээрх дөрвөн суурь баримт бичгүүдийн агуулгад тулгуурлан бусад бүх салбарын бодлого, хууль, эрх зүйн баримт бичиг боловсруулагдах зүй тогтолд тулгуурлах учиртай. Энэхүү зүй тогтлын дагуу 2010 онд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2011 онд Гадаад бодлогын үзэл баримтлал, 2015 онд “Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг батлагдан гарсан. Үүнийг та бид сайтар судлах учиртай.

Сүүлийн асуултыг танд үлдээе ...

-Судлаач хүн судалгааны ажлын үр дүн, бүтээлээ хараад их баярладаг. Тиймээс би ирэх жилүүдэд судалгааны ажлын чанар, үр өгөөж, тоог нэмэгдүүлэх, бие даасан бүтээлээ хэвлүүлэхээс гадна удирдаж буй магистрант, докторантуудынхаа эрдмийн ажлыг хамгаалуулах талаар идэвх зүтгэлтэй ажиллана хэмээн бодож явдаг. Харин уншигчдадаа хандаж хэлэхэд, “Эрдэм ном байгаа газар үргэлж хүсэл тэмүүлэл, инээд хөөр, эерэг энерги цуглаж байдаг. Иймээс номтой сайн нөхөрлөөрэй. Номтой нөхөрлөсөн хүний ирээдүй үргэлж гэрэл гэгээтэй байдаг юм шүү” гэдгийг л хэлье дээ.

Ярилцсан хурандаа Б.ОТГОНБАЯР



Шинжлэх ухааны ажилтны өдрийн хүндэтгэлийн ёслолд ҮБХИС-иас оролцсон эрдэмтэд. 2018 он

Б.Отгон-Уул даргыг тэтгэвэрт гарсны дараа төвийн даргаар Б.Равжаа багш маань томилогдсон. Багш маань ирээд надад “Чи эрдэм номын газар ажиллаж байгаа хүн эрдмийн зэрэг хамгаалах ёстой. Би чиний эрдмийн ажлыг удирдана” хэмээв. Ингээд л Батлан хамгаалахын их сургууль 2010 онд анх удаа аюулгүй байдлаар докторантурын сургалт эхлүүлэхэд нь элсэж байлаа. 2014 онд БХИС-ийн дэргэдэх докторын зэрэг хамгаалуулах зөвлөл дээр “Аюулгүй байдлын орчны өөрчлөлтийн батлан хамгаалах бодлогод үзүүлэх нөлөөлөл” сэдвээр аюулгүй байдлын ухааны доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан. Диссертацийн зөвлөхөөр О.Үржин генерал ажилласан. Энэхүү хоёр оюунлаг хүний буянд эрдэм номын мөр амжилт дүүрэн явна. Одоо би Б.Равжаа багшийнхаа зааж байсан хичээлийг магистрантур, докторантурт суралцагсдад зааж байгаа. Багш маань амьд сэрүүндээ

гэдэгтэй санал нийлэх үү?

-Тэгэлгүй яах вэ. 2019 оны тухайд олон улсын эрдэм шинжилгээний дөрөв, улсын хэмжээний нэг хуралд илтгэл тавьж хэлэлцүүлсэнээс гадна 13 өгүүлэл бичсэн байна. Улсын захиалгатай хоёр судалгааны ажилд гүйцэтгэгчээр, салбарын захиалгатай хоёр судалгааны ажлын удирдагчаар ажилласан жил байлаа. Мөн аюулгүй байдлын чиглэлээр гурван магистрын ажлыг удирдагчаар нь ажиллаж амжилттай хамгаалуулсан. Тэрчлэн аюулгүй байдал, батлан хамгаалах судлалаар магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн даргын хувьд 10 суралцагчийн магистрын зэрэг хамгаалуулах ажлыг зохион байгуулсан. Энэ бүхний үр дүнд өнгөрсөн онд Батлан хамгаалах салбарын тэргүүний судлаачаар шалгарлаа.

Доктор, магистрын сургалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?

СОЁМБО СОНИН
“Соёмбо” сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
Батжаргалын
ОТГОНБАЯР

Эхийг “Соёмбо” сонин
редакцад бэлтгэж,
“Соёмбо принтинг” хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьг үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сонин нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029